




**MINISTÈRE  
DE L'INTÉRIEUR**

*Liberté  
Égalité  
Fraternité*

ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Франц дахь гадаад иргэдийн хэрэг эхрлэх Газар



Францад орогнол  
хүсэгчид зориулсан  
гарын авлага

gDA<sup>2020</sup> оны 9-сар



## ГАРЧИГ

<b>1. Хамгааллын төрлүүд .....</b>	<b>4</b>
1.1. Орогногчийн статус.....	4
1.2. Субсидиар хамгаалал. ....	4
<b>2. Орогнол хүсэх процедур болон бүртгэлд нэвтрэх .....</b>	<b>5</b>
2.1. Орогнол хүсэгчдийг анхлан хүлээн авах.....	5
2.2. Нэгдсэн хүлээн авах цонхонд орогнолын өргөдөл бүртгүүлэх.....	6
2.2.1. Нэгдүгээр үе шат : Префектурт орогнол хүсэх өргөдлөө бүртгүүлэх .....	6
■ Таны орогнолын хүсэлтийг шалгах үүрэгтэй улсыг тодорхойлно .....	6
■ Орогнолын тань өргөдөлийг тодорхойлох. ....	7
■ OFPRA-ийн ярилцлагын хэл сонгох.....	8
■ Орогнол хүсэх эрхийн гэрчилгээ олгох.....	9
■ Орогнолоос бусад шалтгаанаар оршин суух зөвшөөрөл хүсэх боломжууд.....	10
2.2.2. Хоёр дугаар үе шат: OFII-гийн гачигдалт байдлын үнэлгээ болон батлан даалт. ....	10
■ Нэгдсэн хүлээн авах цонхонд онцгой гачигдалт байдлыг тань бүртгэх.....	11
■ Батлан даалтаар хангах. ....	11
2.3. Нэгдсэн хүлээн авах цонхоор бүртгүүлсний дараах халамж.....	12
<b>3. Орогнолын хүсэлтийг шалгах нөхцөлүүд .....</b>	<b>13</b>
3.1. Улс төрийн орогногч ба апатридыг хамгаалах Албаар шалгуулах (OFPRA). ....	13
■ OFPRA-ийн асуулгын хуудас бөглөх.....	13
■ Хавтаст хэргээ OFPRA-д илгээх.....	14
■ OFPRA-д өргөдөл гаргасан тухай нотлох баримт. ....	14
■ Өргөдөлийг шалган үзэх ердийн журам эсхүүл хурдасгасан журам .....	15
■ OFPRA-ийн биечилсэн ярилцлага. ....	15
■ Эрүүл мэндийн үзлэг. ....	16
■ OFPRA-ийн шийдвэр. ....	17
■ OFPRA-ийн шийдвэрийг даван заалдах. ....	18
■ OFPRA-ийн шийдвэр мэдэгдсний дараа нутаг дэвсгэрт байх эрхийн дуусгавар. ....	18
3.2. Орогнолын эрх олгох Үндэсний шүүхээр шалгуулах (CNDA). ....	19
■ Даван заалдах хугацаа.....	19
■ Өмгөөлөгчийн тусалцаа. ....	19
■ Даван заалдах. ....	20
■ Давж заалдах хүсэлтийг хүлээн авсан тухай мэдэгдэл. ....	21
■ Давж заалдахыг түдгэлзүүлэх шинж чанар. ....	21
■ CNDA-ийн шүүх хуралдаан. ....	22
■ CNDA-ийн шийдвэр.....	23
■ CNDA-ийн шийдвэр гарснаас хойш үлдэх эрхийн дуусгавар.....	23
3.3. Хаагдсан орогнолын өргөдлийг дахин нээх.....	24
3.4. Дахин хянах.....	24
<b>4. Орогнол хүсэгчийг хүлээн авах материаллаг нөхцөл, эдлэх эрхүүд .....</b>	<b>26</b>
4.1. Орогнол хүсэгчдийг байрлуулах.....	26
■ Байрлуулах газар. ....	26
■ Орон байрлуу чиглүүлэх.....	27
■ Орон байранд зөвшөөрөгдөх ба түүнээс гарах. ....	27
4.2. Орогнол хүсэгчдэд зориулсан тэтгэмж (ADA). ....	28





■ Түүнийг хүртэх нөхцөлүүд.....	28
■ Өргөдөл гаргах.....	28
■ Тэтгэмжийн хэмжээ.....	29
■ Банкны шилжүүлгэ.....	29
■ Даван заалдах.....	29
<b>4.3. Боловсролд хамрагдах.....</b>	<b>30</b>
<b>4.4. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах.....</b>	<b>30</b>
■ Хаана эмчлүүлэх вэ ? .....	30
■ Эмчилгээний зардал төлөхөд авах туслалцаа хэрхэн олж авах вэ?.....	31
<b>4.5. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх.....</b>	<b>33</b>
<b>5. Орогнол татгалзах ба нутаг дэвсгэрт оршин суух эрхэд нөлөөлөх үр дагаварууд.....</b>	<b>34</b>
<b>5.1. OFPRA болон CNDA-ийн татгалзсан хариу.....</b>	<b>34</b>
■ OFPRA-ийн шийдвэр гарснаас хойш үлдэх эрхийн дуусгавар.....	34
■ CNDA-ийн шийдвэр гарснаас хойш үлдэх эрхийн дуусгавар.....	36
<b>5.2. Эх орондоо тусламжаар буцах.....</b>	<b>36</b>
<b>5.3. Эх орондоо албадан буцаагдах.....</b>	<b>37</b>
<b>6. Хамгаалал хүртэгчдийн эрхүүд.....</b>	<b>38</b>
<b>6.1. Франц улсд оршин суух эрх.....</b>	<b>38</b>
<b>6.2. Гэр бүлийн оршин суух эрх.....</b>	<b>38</b>
■ Гэр бүлийн гишүүдийн оршин суух эрх.....	38
■ Гэр бүл нэгтгэх эрх.....	39
<b>6.3. Интеграцийн зам.....</b>	<b>40</b>
■ Францын Цагаачлал ба интеграцын албатай (OFII) байгуулах Бүгд Найрамдах Улсын интеграцийн гэрээнд гарын үсэг зурах.....	40
<b>6.4. Нийгмийн эрхүүд.....</b>	<b>40</b>
■ Байр орон сууцанд хүрэх.....	40
■ Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэн орох.....	40
■ Эмнэлэгийн үйлчилгээнд нэвтрэх.....	41
■ Нийгмийн болон гэр бүлд олгох халамжууд.....	41
<b>6.5. Гадаадад аялах.....</b>	<b>42</b>
<b>6.6. Францын иргэншил авах /натурализаци.....</b>	<b>43</b>
<b>6.7. Хамгаалал дуусгавар болох.....</b>	<b>43</b>
<b>ХАВСРАЛТ: хэрэгтэй хаягууд.....</b>	<b>45</b>
<b>1. Үндэсний хэмжээнд.....</b>	<b>46</b>
■ Төрийн байгууллагууд.....	46
■ Олон улсын байгууллагууд.....	46
■ Нийгэмлэгүүд.....	46
<b>2. Орон нутгийн хаягууд.....</b>	<b>49</b>
■ Нэгдсэн хүлээн авах цонх.....	49
■ Префектурууд.....	51
■ Францын цагаачлал ба интеграцын Албын орон нутгийн хэлтсүүд (OFII).....	55





## 1. Хамгааллын төрлүүд

Та орогнолын хүсэлт гаргаж, түүнийг шалгаснаар Франц улс хүлээн хариуцах нь тогтоогдвол, таны өргөдөл хамгааллын эрх бүхий байгууллага болох Улс төрийн орогногч ба апатридыг хамгаалах Алба OFPRA-р нарийвчлан шалгуулах бөгөөд энэ нь Орогнолын эрх олгох үндэсний Шүүхийн (CNDA) хяналтын дор явагдана.

Орогнолын тань өргөдлийг шалган үзсэний дараа, хамгааллын байгууллагууд танд орогнолын аль нэг хамгааллын эрх олгож болно: нэг бол таныг орогногчоор хүлээн зөвшөөрнө, нэг бол субсидиар хамгаалал эдлэхийг зөвшөөрнө.

### 1.1. Орогногчийн статус.

Орогногчийн статусыг гурван үндэслэл дээр тулгуурлаж олгоно :

- Орогногчийн статусын тухай 1951 оны 7-р сарын 28-ны өдрийн **Женевын конвенц**. Орогногчийн статусыг « арьс өнгө, шашин шүтлэг, үндэс язгуур мөн түүнчлэн аливаа нэгэн нийгмийн бүлэгт хамрагдсанаас юм уу, эсхүүл улс төрийн үзэл бодлоосоо шалтгаалан дарамт шахалтанд орхоос айдаг буюу, харъяат улсынхаа хийлийн гадна байгаа бөгөөд өөрийн улсаас хамгаалал хүсэх боломжгүй, эсхүүл дээр дурьдсан аюулаас үүдэн өөрийн улсаас хамгаалал гуйх хүсэлгүй байгаа аливаа хүнд олгоно » ;
- **“Үндсэн хуулийн” гэх орогнолын тухай** 1946 оны Үндсэн хуулийн оршил хэсгийн 4-р зүйлд заасны дагуу, улс төрийн орогногчийн статусыг *“Эрх чөлөөний төлөөх үйлдлээсээ заналхийлэлд өртсөн аливаа хүнд”* олгоно ;
- **Нэгдсэн Үндэстний байгууллагын Орогногчдын Дээд Зөвлөлийн (HCR) мандатаар:** HCR-ийн 6-р болон 7-р зүйл ангийн дагуу орогногчоор хүлээн зөвшөөрөгдсөн бол.

### 1.2. Субсидиар хамгаалал.


Субсидиар хамгааллыг улс төрийн орогногчоор хүлээн зөвшөөрхөд шаардагдах нөхцөлүүдийг хангаагүй хэдий ч, өөрийн улсдаа доорхи аюул заналхийлэлийн аль нэгэнд өртсөн, эдгээр эрсдэлийн ноцтой шалтгаан, түүний нотолгоо байгаа нь илэрхий аливаа хүнд олгоно:

- Цаазаар авах ял эсбол цаазын ял хэрэгжүүлэлт ;
- Эрүүдэн шүүх, хүн бусаар яллах буюу зүй бусаар харьцах, доромжлох ;
- Энгийн иргэнд, нийтийг хамарсан хүчирхийлэлийн байдлаас мөн түүнчлэн дотоодын эсхүүл олон улсын зэвсэгт мөргөлдөөнөөс үүдсэн, ноцтой аюул амь нас болон биед нь шууд тулгарсан тохиолдолд.

#### Апатридын статус

Апатридын тухай 1954 оны 9-р сарын 28-ны Нью-Йоркийн конвенцид зааснаар, апатридын статусыг *“аль ч Төр хууль тогтоомжийнхоо дагуу өөрийн иргэн болохыг хүлээн зөвшөөрөөгүй”* нэгэнд олгоно. Энэхүү статус нь дээр дурдсан хоёр хамгааллын төрлүүдээс ялгаатай бөгөөд орогнол хүсэх журамд хамаарахгүй болно. Иймээс та префектурт хандах шаардлагагүй, шууд OFPRA-д хандах бөгөөд, тэр нь, өргөдөлийг тань шалган үзсэний дараа, захиргааны шүүхийн хууль зүйн хяналтын дор, уг статусын эрхийг танд зөвшөөрөх болно.





## 2. Орогнол хүсэх процедур болон бүртгэлд нэвтрэх

Францад орогнол хүсэх өргөдөлөө өгөхийн тулд хамгийн түрүүнд орогнол хүсэгчдийг анхлан хүлээн авагч нэгэн бүтэцтэй (SPADA) холбогдох шаардлагатай бөгөөд, тэр нь орогнол хүсэх журмын талаар мэдээллэж, орогнол хүсэгчдэд зориулсан нутаг дэвсгэрийн эрх бүхий нэгэн Нэгдсэн хүлээн авах цонхонд цаг товлон олгох болно.

### Ямар оршин суух нөхцөл байдлаас шалтгаалан орогнолын өргөдөл гаргаж болох вэ?

Та, оршин сууж буй эрхийнхээ нөхцлөөс үл хамааран, дүрэм ёсоор ч бай эсхүүл дүрэм бусаар ч байсан, орогнолын өргөдөл гаргаж болно. Франц улсад дүрэм бусаар орж ирсэн тань орогнолын хүсэлтээ бүртгүүлэхэд тань саад болохгүй.

Та нутаг дэвсгэрт нэвтрэн орж ирсэн даруйдаа, Франц улсад хүчин төгөлдөр визтэй байсан ч, аль болох түргэн хугацаанд орогнол гүйх хүсэлтээ бүртгүүлхийг зөвлөж байна. Та өргөдлөө Францад нэвтрэн орсноос хойш 90 хоногоос дотогш хугацаанд гаргаагүй тохиолдолд, танд дэмжлэгэ үзүүлхээс татгалзаж болно.

### 2.1. Орогнол хүсэгчдийг анхлан хүлээн авах.

Орогнол хүсэгчдийг хүлээн авах Нэгдсэн хүлээн авах цонхонд (GUDA) хандхаас өмнө, та орогнол хүсэгчдийг анхлан хүлээн авагч нэгэн бүтэц дээр (SPADA) очиж өөрийгөө танилцуулах ёстой. Нэгдсэн хүлээн авах цонх нь таны орогнолын хүсэлтийг бүртгэх үйл явцыг хариуцах, таны мөрдөх журмыг тодорхойлох, эмзэг байдалд тань үнэлгээ өгөх, улмаар, тодорхой нөхцлийн дагуу, хүлээн авах материаллаг нөхцөлүүдийг гардуулах болно (орон байр, орогнол хүсэгчдийн тэтгэмж).

Анхлан хүлээн авах үүрэгтэй эдгээр бүтэцүүдийг, зарчмын хувьд, нийгэмлэгүүд удирддаг бөгөөд эдгээр нь таны орогнолын процедурт хүрэх алхмуудад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Анхны хүлээн авахыг хариуцсан операторууд дараахь зүйлийг хариуцна :


- Танд орогнолын процедурын талаар мэдээлэх;
- Таны аж байдлын талаархи мэдээлэл дээр үндэслэн, орогнолын тань өргөдлийг бүртгүүлэхэд шаардагдах онлайн маягыг бөглөх;
- Нэгдсэн хүлээн авах цонхонд уулзалтын цаг авч, танд дуудах хуудас өгөх. Үүнд Нэгдсэн хүлээн авах цонхны байршил, зайлшгүй хүрэлцэн очих, огноо, цагийг заах болно. Зарчмын хувьд тэр уулзалтын цагт, оператор дээр очсноос хойш дээд тал нь 3 өдрийн дараа очсон байна. Ачаалал өндөр үед энэ нь 10 өдөр хүрч болно ;
- Нэгдсэн хүлээн авах цонхонд шаардах тул цээж зургаа авч очих.

Таны хавтаст хэргийг Нэгдсэн хүлээн авах цонхруу материаллаг бусаар дамжуулах болно.

**АНХААРУУЛГА:** Та дуудах хуудас дээр заасан огноо, цаг хугацааг зайлшгүй мөрдөх ёстой. Хоцорсон тохиолдолд, таныг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд та шинээр цаг авхын тулд анхлан хүлээн авах бүтэцдээр дахин хүрэлцэн очих шаардлагатай болно.

Нэгдсэн хүлээн авах цонхонд бүртгүүлсний дараагаар, орогнол хүсэгчдийг хүлээн авах төв (CADA) эсхүүл, таныг ямар нэгэн орогнол хүсэгчдийг тогтвортой байрлуулах бүтэц байрлуулаагүй бол, SPADA нь бас таныг өөр дээрээ хаягийн тодорхойлолттой болгох үүрэгтэйг анхаарна уу (2.2.1-рт "Хаягаа хэрхэн нотлох вэ?" хэсгийг үзнэ үү).





## 2.2. Нэгдсэн хүлээн авах цонхонд орогнолын өргөдөл бүртгүүлэх.

Орогнолын хүсэлтээ бүртгүүлэхийн тулд та SPADA-аас олгосон дуудах хуудас дээр заасны дагуу, Нэгдсэн хүлээн авах цонхонд хүрэлцэн очих ёстой (2.1-ийг үзнэ үү).

Нэгдсэн хүлээн авах цонхон нь Префектур, мөн түүнчлэн Францын цагаачлал ба интеграцийн Албын (OFII) ажилтнуудаас бүрдсэн байх бөгөөд эдгээр нь таныг хүлээн авах нөцлөөр хангах үүднээс тусгайлан цуглардаг.

Улсын нутаг дэвсгэр дээр нийт 33 Нэгдсэн хүлээн авах цонх үйлчилдэг (жагсаалтыг хавсралтаас үзнэ үү).

Нэгдсэн хүлээн авах цонх нь хоёр үе шатаар хүлээн авна :

- Нэгдүгээр үе шатанд, Префектурын албаныхан таны өргөдлийг бүртгэх зорилгоор юм (2.2.1) ;
- Хоёрдугаар үе шатанд, OFII-ийн төлөөлөгчид, таны хувийн байдалд үнэлгээ хийж батлан даалтын нөхцөлийг тодорхойлох зорилгоор (2.2.2).

### Орогнолын өргөдлөө бүртгүүлэхийн тулд та шуудангийн хаягтай байх уу?

Орогнолын өргөдлөө бүртгүүлэхийн тулд та хаягийн тодорхойлолтой (шуудангийн хаяг) байх шаардлагагүй.

Түүнчлэн, тэр нь танд орогнол хүсэх эрхийн гэрчилгээгээ сунгахад шаардлагатай болно (2.2.1-рт "орогнол хүсэх эрхийн гэрчилгээ олгох" хэсгийг үзнэ үү).

### 2.2.1. Нэгдүгээр үе шат : Префектурт орогнол хүсэх өргөдлөө бүртгүүлэх

#### Таныг насанд хүрээгүй хүүхдүүд тань дагалдан яваа бол?

Хэрэв таныг насанд хүрээгүй хүүхдүүд тань дагалдан яваа бол тэд бас орогнол хүсэгчээр тооцогдох бөгөөд таны орогнол хүсэх эрхийн гэрчилгээнд бүртгэгдэх болно. Хэрэв эцэг эх хоёулаа орогнол хүсэгчид бол насанд хүрээгүй хүүхдүүд нь ээжийн гэрчилгээнд бүртгэгддэг буюу, нийт процедурын туршид тэдэнд хамааралтай эцэг эх гэж үзнэ. Энэхүү баримт бичиг нь танай гэр бүлийн бүрэлдэхүүнийг бус, зөвхөн орогнолын хүсэлт явагдаж буйг гэрчлэх юм.


#### ■ Таны орогнолын хүсэлтийг шалгах үүрэгтэй улсыг тодорхойлно

Нэгдсэн хүлээн авах цонхруу орогнол хүсэгчдийг анхлан хүлээн авах бүтэцээс дамжуулсан нийт мэдээллүүдийг лавлан баталгаажуулсны дараа, орогнолын тань хүсэлтийг Франц улс хариуцах эсэхийг Префектурын ажилтан тодорхойлно.

Үүний тулд та 14 ба түүнээс дээш настай бол таны арван хурууны хээний дардас авч тантай ганцаарчилсан ярилцлага хийнэ. Зорилго нь эх орноосоо гарсан өдрөөс хойш та хаагуур дамжин өнгөрснийг, мөн гишүүн Улсуудад танд ямар нэг холбоо байгаа эсэх, яалангуяа гэр бүлийн харилцаа холбоо байгаа эсэхийг тогтоох юм.

Эдгээр элементүүд дээр үндэслэн, таны орогнолын хүсэлтийг хариуцан авч шалгах улсыг, Дублины III-р тогтоомж хэмээх 2013 оны 6 сарын 26-ны Европын Парламентийн болон Зөвлөлийн n°604/2013 -р тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.





### Дублины III-р тогтоомжид хамааралтай улс орнууд

Эдгээр нь Европын Холбооны 28 гишүүн: Герман, Австри, Бельги, Болгар, Хорват, Кипр, Дани\*, Испани, Эстони, Финланд, Франц, Грек, Унгар, Ирланд, Итали, Латви, Литва, Люксембург, Мальт, Голланд, Польш, Португаль, Чех улс, Румын, Нэгдсэн Вант улс, Словак, Словен болон Швед, мөн түүнчлэн дөрвөн хамтрагч улс: Исланд, Норвеги, Швейцарь ба Лихтенштейн зэрэг болно.

\*Дани улс хэдий Дублины 2-р Тогтоомжинд гарын үсэг зураагүй ч 1990 оны 6-р сарын 15-ны Дублины конвенцыг хэрэгжүүлсээр байгаа

**Гэтэл Франц биш Европын өөр нэгэн улс орогнолын тань хүсэлтийг хариуцхаар тогтоогдож болох юм, жишээлбэл :**

- танд Европын Холбооны Гишүүн өөр нэгэн улс хугацаа хүчинтэй оршин суух эрхийн бичиг эсхүүл виз олгосон бол;
- Европын Холбооны Гишүүн өөр нэгэн улсын гадаад хилийг газраар, агаараар эсбол усан замаар дүрэм бус давж ирсэн тань тогтоогдсон бол;
- Европын Холбооны нутаг дэвсгэрт орж ирэхдээ эхлээд визээс чөлөөлөгдсөн өөр нэгэн Гишүүн улсын хил давж ирсэн бол;
- Та өөр нэгэн Гишүүн улсаас орогнол хүсч байсан бол.

### Таны орогнолын өргөдлийг шалгаснаар Европын өөр нэгэн улсын хариуцлагт ноогдож болзошгүй байгаа бол яах вэ?

Та « Дублин III » хэмээх процедурт хамрагдлаа. Энэ тохиолдолд Префектур уг улстай холбогдож таныг хариуцан авах хүсэлт гаргана. Танд нэг сарын хүчинтэй орогнол хүсэх эрхийн гэрчилгээ олгох бөгөөд тэр нь дөрвөн удаа сунгагдах боломжтой. Энэхүү бичиг нь орогнолын хүсэлтийг тань хариуцах үүрэгтэй улсруу шилжүүлэх хүртэл Францын нутаг дэвсгэрт байх зөвшөөрөл танд олгоно.

Уг шилжүүлэх ажлыг Префектурын хэлтсүүд зохион байгуулна. Таныг шилжүүлэх тухай шийдвэр дуулгах бөгөөд үүнд явуулах нөхцөлүүдийг тодруулсан байх болно. Та уг шийдвэрийг эсэргүүцэх бол 15 хоногийн дотор Захиргааны шүүхэд хандаж болно.


### ■ Орогнолын тань өргөдлийг тодорхойлох.

Таны орогнолын хүсэлтийг Франц улс шалган хариуцах нь тогтоогдсон бол, түүнийг шалгах эрх бүхий байгууллага OFPRA нь, ердийн эсхүүл хурдасгасан журмаар гүйцэтгэх болно. Хурдасгасан журмын дагуу OFPRA-ийн шалгалтын хугацааг богиносгодог ба зарчмын хувьд тэр нь арван таван хоног бөгөөд нийт үйл ажиллагааны баталгаа хоёуланд нь ижил байдаг.

- **Таны өргөдөл** Нэгдсэн хүлээн авах цонхноос **хурдасгасан журамд шууд орох** хоёр нөхцөл нь :
  - Хэрэв таны харьяалал аюулгүй улсын гарал үүсэлтэй бол (эдгээр улсын жагсаалтыг Префектурээс эсбол OFPRA-ийн вэбсайтаас үзэх боломжтой);
  - Хэрэв таны анх гаргасан орогнолын өргөдлийг бүр мөсөн татгалзсан тул та дахин хянуулхаар хүсэлтээ өгч байгаа бол;







- **Таны өргөдөл** Нэгдсэн хүлээн авах цонхноос **хурдасгасан журамд** доор дурдсан тохиолдолд **орно** :
  - хэрэв та хурууныхаа дардсыг өгөхөөс татгалзвал;
  - хэрэв та эрх бүхий байгууллагуудыг төөрөгдөлд оруулхыг завдан хуурамч бичиг баримт бүрдүүлэн, худал мэдүүлгээр хангаж эсхүүл зарим мэдээллийг нуун дарагдуулсан бол;
  - хэрэв та олон өөр овог нэрээр хэд хэдэн өргөдөл гаргасан бол;
  - хэрэв та Францад орж ирснээсээ хойш орогнолын хүсэлт гаргах аа оройтуулсан бол (90-с дээш хоног, Гаянад 60-с дээш хоног);
  - хэрэв та нутаг дэвсгэрээс холдуулах арга хэмжээнээс зайлхийх зорилгоор орогнолын өргөдөл гаргасан бол;
  - хэрэв та нутаг дэвсгэрт байснаар нийтийн хэв журам, нийгмийн болон үндэсний аюулгүй байдалд ноцтой аюул занал үзүүлж байгаа бол.

OFPPA нь, бүртгэлийн явцад хурдасгасан ангилалд хамрагдсан өргөдлийг өөрчилж ердийн ангилалруу шилжүүлэх чадвартай ч тэр нь зөвхөн нийтийн хэв журмын асуудлаар хурдасгасан журамд орсон тохиолдолд юм.

Хэрэв таны орогнолын өргөдлийг хурдасгасан журамд оруулсан бол тайлбар бичиг хэд хэдэн хувиар өгөх болно. Нэг хувийг нь OFPPA-д өргөдлөө гаргахдаа, өөр нэг хувийг OFPPA-ийн шийдвэрийг давж заалдах бол CNDA-д илгээнэ.

#### **Онцгой тохиолдол: Та Захиргааны эсхүүл Шүүхийн албадан холдуулах эсбол нутаг дэвсгэрийн хорио заасан захирамжинд хамрагдсан уу?**

Хэдийгээр та дээрхи захирамжинд хамрагдсан ч, холдуулах арга хэмжээ нь орогнолын өргөдөл гаргахад тань саад болохгүй.

Хэрэв таны өргөдлийг Франц улс хариуцах нь тогтоогдсон бол таныг гэрийн хорионд оруулах шийдвэр мэдүүлэх эсхүүл захиргааны саатуулганд байрлуулж магадгүй юм.

Гэрийн хорио заасан эсхүүл захиргааны саатуулганд байрлуулсан тохиолдолд, OFPPA хүсэлтийг тань товчилсон хугацаанд (96 цаг) хянаж үзнэ. Татгалзсан эсүүл хүсэлтийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн нутаг дэвсгэрт байх эрхийг хүчингүй болгоно. Тэрчлэн, давж заалдах өргөдлийг тань CNDA хэлэлцэх хугацаанд, та албадан холдуулах шийдвэрийн гүйцэтгэлийг түдгэлзүүлэх өргөдөл Захиргааны шүүгчд 48 цагийн дотор гаргаж болно (5.1 хэсгийг үзнэ үү).

#### **■ OFPPA-ийн ярилцлагын хэл сонгох.**

**Хэрэв таны өргөдлийг Франц улс хариуцах нь тогтоогдсон бол**, үл хамаарах нөхцлөөс бусад тохиолдолд, та OFPPA-д өргөдлөө бичгээр оруулсны дараа, OFPPA дээр хувийн ярилцлага өгнө. Та орогнолын өргөдлөө бүртгүүлэхдээ OFPPA-дээр асуугдахыг хүсч буй тэр хэлээ сонгох шаардлагатай. Танд OFPPA-дээр ярилцлага явуулж болох олон хэлүүдийг заасан нэгэн мэдээллийн хүүдас өгөх ба нийт 115 гаруй хэл байх болно.


Энэ сонголтыг дараа нь өөрчлөх боломжгүй бөгөөд цаашид тухайн хэл нь таны орогнолын хүсэлтийг хянах бүх процедурын явцад хэрэгдэгдэх болно.

Хэрэв та мэдээллийн хуудсанд дурдсан хэлнээс сонголт хийгээгүй бол, таны хангалттай мэддэг нэгэн хэлдээр ярилцлага хийгдэх болно.

Хэрэв та орогнол олгох явцад хэрэглэсэн хэлний сонголтын талаар заргалдахыг хүсч байгаа бол та зөвхөн CNDA-д давж заалдах хүрээнд, OFPPA-ийн орогнолын тань хүсэлттэд гаргасан шийдвэрийн эсрэг хийж болно.







**АНХААРУУЛГА:** OFPRA дахь ярилцлагын хугацаа, мөн шинж чанар нь хэлний өнгөц практикаас илүү мэдлэгэ шаарддаг. Та сонгосон хэлээ ойлгож, тухайн хэлээр өөрийгөө илэрхийлэх чадвартай байх нь чухал юм.

### ■ Орогнол хүсэх эрхийн гэрчилгээ олгох.

Таны орогнолын хүсэлтийг хариуцах Улсыг тогтоож мөн түүний процедурт үнэлгээ өгч тодорхойлсны дараа танд орогнол хүсэх эрхийн гэрчилгээ олгох болно.

**Таны өргөдлийг шалгаж өөр нэгэн гишүүн Улс хариуцах үүрэгтэй болох магадлалтай** бол эхний гэрчилгээний хугацаа нь нэг сарын хүчинтэй байх болно. Үүнийг дөрвөн сарын хугацаагаар сунгана (2.2.1-рт "Таны орогнолын хүсэлтийг шалгах үүрэгтэй улсыг тодорхойлно" хэсгийг үзнэ үү).

**Таны өргөдлийг шалгаж Франц Улс хариуцах үүрэгтэй болох нь тогтоогдсон бол** эхний гэрчилгээг олгоно. Энэхүү гэрчилгээний хүчинтэй хугацаа :

- Ердийн процедурын дагуу явагдах тохиолдолд хүчинтэй хугацаа нь 10 сар байна.

- Түргэвчилсэн процедурын дагуу явагдах тохиолдолд хүчинтэй хугацаа нь 6 сар байна.

Префектур танд доорх тохиолдолуудад орогнол хүсэх эрхийн гэрчилгээ олгохоос татгалзаж болно :

- Та, өмнө нь дахин хянуулах өргөдөл гаргаж татгалзан хариу авсны араас, шинээр дахин хянуулах хүсэлт гаргаж буй бол (3.4. -г үзэх) ;
- Таны эсрэг, эх орноос тань өөр улсад шилжүүлэн өгөх эцсийн шийдвэр гарсан, эсхүүл Европын баривчлах мандат, мөн түүнчлэн олон улсын эрүүгийн шүүхээс шилжүүлэн өгөх тухай шийдвэр дээр үндэслэн, таныг хүлээлгэн өгөх шийдвэр гарсан бол.

Танд гэрчилгээ гардуулсан өдрөөс 21 хоногийн дотор (хэргээ дахин хянуулах буюу шинээр нээлгэх тохиолдолд 8 өдөр, 3.3 ба 3.4-р хэсгийг үзэх), Префектурээс олгосон орогнол хүсэх өргөдлийн маягтыг OFPRA-д илгээх үүрэгтэй болно (3.1-рт « OFPRA-аар хянуулах » хэсгийг үзэх). Хэрэв таны хавтаст хэрэг бүрдсэн бол OFPRA захидлаар хүлээн авсан нотолгоо хүргүүлнэ.

Орогнол хүсэх эрхийн гэрчилгээгээ сунгуулахдаа, та өөрийн оршин сууж буй мужийн Префектурт очиж хандах ёстой. Уг гэрчилгээний сунгалтын хугацаа нь ердийн процедур эсхүл хурдасгасан процедурын аль нь байхаас үл хамааран зургаан сарын түрш хүчинтэй байх болно.

Хугацаа шинэчлүүлэх бүртээ, та Префектурээс шаардсан бичиг баримтуудыг, ялангуяа оршин сууж буй хаягийнхаа нотолгоог бүрдүүлж өгөх шаардлагатай болно. Түүнчлэн та CNDA-д давж заалдах өргөдөл гаргасан гэдгээ баталгаажуулахын тулд та давж заалдах өргөдөл хүлээн авсан тухай мэдүүлэгийг гардуулах ёстой (3.2-рт "Орогнолын эрх олгох үндэсний шүүхээр шалгуулах" хэсгийг үзнэ үү).



**Оршин суух хаягаа хэрхэн нотлох вэ?**

2019 оны 1-р сарын 1-ний өдөр буюу түүнээс хойш бүртгэгдсэн орогнолын өргөдөлтэй бол та дараах байдлаар хаягаа нотолж болно:

- хэрэв та орогнол хүсэгчдэд зориулсан хүлээн авах төвд байрладаг эсбол орогнол хүсэгчдэд зориулсан бусад бүтэцийн байнгын байранд (зочид буудлаас бусад) байрладаг бол орон байрны тодорхойлолт бүрдүүлснээр;

- хэрэв та өөрийн эзэмшлийн, түрээсийн, эсбол эхнэр /нөхөр/хүүхэд/ өв залгамжлагчийн эзэмшдэг / орон сууцанд амьдардаг бол орон байрны нотлох баримт;

- бусад тохиолдол нь, та гэрээт тохиролцооны хүрээнд анхны хүлээн авах бүтцэд оршин суудаг бол, оршин суух тодорхойлолт бүрдүүлснээр (2.1-ийг үзэх);

2019 оны 1-р сарын 1-ний өдрөөс өмнө бүртгэгдсэн орогнолын өргөдөлтэй бол, та дээр дурдсан нөхцлийн дагуу байрлаж болох бөгөөд шаардлагатай бол гуравдагч этгээдийнд байрлаж болно.

Энэхүү орогнол хүсэх эрхийн гэрчилгээ нь тухайн нутаг дэвсгэрт байх эрхтэй нийт хугацааны түршид сунгагдана. Зарчмын дагуу, таны орогнолын өргөдлийг хянах нийт хугацаанд OFPRA -ийн шийдвэрийг мэдэгдэх хүртэл, эсбол CNDA-ийн өмнө давж заалдсан тохиолдолд шийдвэрийг мэдэдүүлэх, шаардлагатай бол нээлттэй шүүх дээр үнших хүртэлх хугацаанд, та нутаг дэвсгэрт байх эрхтэй .

Гэсэн хэдий ч, дараах тохиолдолд орогнол хүсэх эрхийн гэрчилгээг хураан авах эсбол сунгахаас татгалзах болно, үүнд :

- OFPRA танд татгалзсан эсбол хүлээн авашгүй шийдвэр гаргаснаар нутаг дэвсгэрт байх эрх тань дуусгавар болох (5.1.-рт "OFPRA болон CNDA-ийн татгалзсан шийдвэр "- ийг үзнэ үү).

- CNDA-д давж заалдах өргөдөл гаргах хугацааг мөрдөөгүй нь тодорхой бол (3.2-рт "Орогнолын эрх олгох үндэсний шүүхээр шалгуулах" хэсгийг үзнэ үү).


**АНХААРАХ:** Орогнол хүсэх эрхийн гэрчилгээ нь танд Европын холбооны бусад орнуудад чөлөөтэй зорчих боломжийг олгохгүй.

**■ Орогнолоос бусад шалтгаанаар оршин суух зөвшөөрөл хүсэх боломжууд.**

Хэрэв таны орогнолын өргөдлийг шалгаж Франц улс хариуцах үүрэгтэй болох нь тогтоогдсон бол, танд орогнолоос бусад шалтгаанаар оршин суух эрхийн бичиг хүсэх боломжийг мэдээллэнэ.

Танд нэгэн мэдээллийн товхимол өгөх бөгөөд үүнд тус хүсэлтийг гаргах боломжтой хугацааг заасан байна. Энэ хугацааг хэтэрсний дараа, шинэ шалтгааны үндэслэлгүй бол, та оршин суух зөвшөөрөлийн эрх хүсэх боломжгүй.

**2.2.2. Хоёр дугаар үе шат: OFII-гийн гачигдалт байдлын үнэлгээ болон батлан даалт.**



## ■ Нэгдсэн хүлээн авах цонхонд онцгой гачигдалт байдлыг тань бүртгэх.

Нэгдсэн хүлээн авах цонхоор орох үеэр мөн орогнолын хүсэлтээ Префектурт бүртгүүлсний дараа, OFII-ийн төлөөлөгч таны тодорхой хэрэгцээг үнэлж хүлээн авах материаллаг тусалцааны үүднээс ганцаарчлан хүлээн авах болно.

Ярилцлагын агуулга нууц байх бөгөөд таны орогнол хүсч буй шалтгаантай хамааралгүй. Хүлээн авах нөхцлийн онцгой шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд танаас нэгэн жагсаалтын дагуу асуулт тавих болно. Хэрэв таны нөхцөл байдал үүнийг шаардаж байгаа бол тус элементүүдийг OFII-ийн ажилтан нь анхааралдаа авч тохирох орон сууцруу таныг чиглүүлэх болно.

Та санал асуулгад хариулахыг зөвшөөрөх эсбол татгалзах бүрэн эрхтэй. Хэрэв татгалзсан тохиолдолд, таны хэрэгцээнд тохируулж чадаагүй орон сууцанд чиглүүлсэн байх, эсбол таны тухай тайланг OFPRA-д мэдээллээгүйн хариуцлагыг захиргаа үл хүлээх болно.

Хэрэв та Францад эмнэлгийн хавтаст хэрэгтэй ирвэл OFII-ийн төлөөлөгч таны хэргийг нууцалсан дугтуйгаар OFII-ийн эмчид түүнийг илгээх бөгөөд тэр нь хүлээн авах нөхцлийг таны байдалд тохируулах эсэхийг шийдэх юм. Хэрэв таны бие өвдвөл, таныг нэгэн эмнэлгийн байгууллага эсбол хамгийн ойрын эмнэлгийн түргэн тусламжийн хэсэг рүү чиглүүлэх болно.

Хэрэв OFII-ийн ажилтан эмзэг нөхцөл байдал тодруулсан бол үүнийг, таны зөвшөөрөлтэйгээр, OFPRA-д мэдээлэх болно. Энэхүү мэдээллийн зорилго нь, шаардлагатай бол, OFPRA-аар орогнолын өргөдлийг тань боловсруулах нөхцөлийг тохируулах явдал юм (жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэвтрэн орох боломжийг тохируулах, эсбол дохион хэлний орчуулагчаар хангах).

OFPRA нь өөрөө шаардлагатай тохируулгыг тооцоолон гаргах болно.

Эмзэг нөхцөл байдалтай хүмүүсийн хэрэгцээг орогнолын хүсэлтийг нь хянан үзэх бүхий л хугацаанд тооцон үзэх бөгөөд орон байрны бүтэц дэх нийгмийн ажилтнууд болон тусламжийн нийгэмлэгүүд анхааран үзэж захиргааны бичиг баримт болон нийгмийн хөөцөлдөх ажилд халамж үзүүлэх болно.

## ■ Батлан даалтаар хангах.

Таныг Нийтийн хүлээн авах цонхоор орох явцад, OFII нь танд батлан даалтаар хангах санал болгох бөгөөд, тэр нь танд орогнолын шалтгаанаар нутаг дэвсгэрт байх эрх эдлэх хугацаандаа, хүлээн авах материаллаг нөхцлийг хүртэх боломжийг олгох юм.


Танд Нийтийн хүлээн авах цонхонд олгосон OFII-ийн батлан даалт хүртэх баримт бичиг дээр гэр бүлийн тань бүрэлдэхүүнийг зааснаар, хүлээн авах материаллаг нөхцлийг хүртэх эрх, түүний тодорхой түвшинг илтгэх юм.

Энэ баримт бичиг нь орогнол хүсэх процедурын явцад хүүхэд төрөх эсбол эцэг эхтэйгээ нэгдэх үед, хүлээн авах материалыг нөхцөл хүртэх эрхийг дахин тооцоолон, шинээр OFII-ээс хэвлэгдэх болно.

Энэхүү гарын авлагын 4-р хэсэгт заасны дагуу, хүлээн авах материаллаг нөхцөлүүд нь танд дараах эрхийг олгоно:

- Хэрэв та орон байргүй бол, батлан даалтаар хангуулж орон байрлуу чиглүүлж өгөхийг хүсэх (4.1-рт "Орогнол хүсэгчийг байрлуулах" хэсгийг үзэх). ;
- хуульд зааснаас бусад тохиолдолд, орогнол хүсэгчдэд олгох тэтгэмж хүртэх (4.2.-рт "Орогнол хүсэгчдэд зориулсан тэтгэмж" -ийг үзэх).





Хэрэв аль нэгэн мужид хүлээн авах бүтэцүүд хэт ачаалалтай тохиолдолд, OFII нь таныг өөр нэгэн мужруу чиглүүлэх бөгөөд тэнд та өргөдлийг тань хянан үзэх хугацаанд оршин суух болно (4.1-рт "Орогнол хүсэгчийг байрлуулах" хэсгийг үзэх).

### 2.3. Нэгдсэн хүлээн авах цонхоор бүртгүүлсний дараах халамж.


Нийтийн хүлээн авах цонхоор орсны дараа, таны байрлаж байгаа орогнол хүсэгчдэд зориулсан хүлээн авах төв (CADA) эсбол тогтвортой гэх, орогнол хүсэгчдийг яаралттай байрлуулах орон байранд, үзүүлэх халамжуудийг танд санал болгоно (зочид буудал бус).

Хэрэв таныг эдгээрт байрлуулаагүй бол, OFII нь анхны хүлээн авах бүтэц болох (SPADA)-руу чиглүүлснээр тэд нь таныг зрхих халамжаар хангах болно (2.1 хэсгийг үзэх).

Энэхүү нийгмийн болон хууль эрхзүйн мөн захиргааны дэмжлэг нь оршин суух хаягийн тодорхойлолтыг хамаарах бөгөөд (2.2.1-рт "Оршин суух хаягаа нотлох" хэсгийг үзэх), түүнчлэн хэрэв таны орогнолын өргөдлийг Франц Улс хариуцах үүрэгтэй бол, OFPRA-д хүргэх орогнолын хүсэлт бүхий хавтаст хэргийг тань бүрдүүлхэд тусалцаа үзүүлнэ.

АНХААРУУЛГА: Хэрэв та SPADA-д оршин суудаг хаягтай бол, SPADA-аас тогтоосон зааварчилгааг харгалзан захидалаа тогтмол очиж авч байх нь таны үүрэг юм.





## 3. Орогнолын хүсэлтийг шалгах нөхцөлүүд

Та орогнолын хүсэлтээ гаргахад, түүнийг шалгаснаар Франц улс хүлээн хариуцах нь тогтоогдвол, таны өргөдөл хамгааллын эрх бүхий байгууллага болох Улс төрийн орогногч ба апатридыг хамгаалах Алба OFPRA-р нарийвчлан шалгуулах бөгөөд энэ нь Орогнолын эрх олгох үндэсний Шүүхийн (CNDA) хяналтын дор явагдана.

### 3.1. Улс төрийн орогногч ба апатридыг хамгаалах Албаар шалгуулах (OFPRA).

Орогнолын өргөдлөө Префектурт бүртгүүлхэд, танд OFPRA-д илгээх ёстой орогнол хүсэх өргөдлийн асуулгын хуудас олгох бөгөөд, түүнийг бөглөж илгээснээр, OFPRA шалган үзэж шийдвэр гаргах болно.

OFPRA-ийн татгалзсан шийдвэрийг CNDA-д давж заалдах боломжтой (3.2-рт Орогнолын эрх олгох үндэсний Шүүхээр шалгуулах).

Та анх орогнол хүсэх өргөдлөө гаргахдаа, хүсэж буй хамгаалалтын төрлийг заах шаардлагагүй (орогногчийн статус эсбол субсидиар хамгаалалт гэх зэрэг). Учир нь таны орогнол хүсэх явцад, өргөдлийг тань OFPRA өвөрмөц журмаар хянан үзээд юуны түрүүнд орогногчийн статустай харьцуулж, дараа нь хэрэв таны нөхцөл байдал үүнээс хамааралгүй бол субсидиар хамгаалалтын хүрээнд судлах болно.

#### ■ OFPRA-ийн асуулгын хуудас бөглөх.


**Асуулгын хуудсыг франц хэл дээр бөглөсөн байх**, гарын үсэг болон хугацаа хүчин төгөлдөр орогнол хүсэх эрхийн бичгийн хуулбар, хоёр хувь цээж зураг болон, хэрэв танд байвал аялах эрхийн биеийн байцаалт зэргийг хавсруулах.

Хэрэв таны орогнолын өргөдлийг хурдасгасан журамд хамруулсан тохиолдолд, танд өргөдөл бүртгүүлэх үед олгосон мэдээллийн хуудсын хуулбарыг хамт илгээх шаардлагатай.

Эдгээр баримтууд нь таны өргөдлийг OFPRA-д бүртгүүлэхэд зайлшгүй шаардлагатай байх болно.

Хэрэв дагалдан яваа бага насны хүүхдүүд тань аюулд орох эрсдэлтэй бол, түүнийг орогнол хүссэн өргөдлийнхөө асуулгын маягт дээр дурдах нь зүйтэй. Хэрэв эцэг эх хоёулаа орогнол хүсэж байгаа бол, дагалдаж буй насанд хүрээгүй хүүхдийн аливаа айдсыг эхийн маягт дээр тэмдэглэнэ.





Таны орогнол хүсэх өргөдөлд агуулж буй мэдээллүүд нь нууц байх бөгөөд ямар ч тохиолдолд танай эх орны эрх баригчдад хүргэгдэхгүй.

## ■ Хавтаст хэргээ OFPRA-д илгээх.

Өргөдлөө бүрэн гүйцэд бөглөсний дараа **та хамгийн цаад хугацаа болох 21 дэх хоног дотроо багтаагаад илгээх ёстой**. (Өргөдөл дахин нээлгэх хүсэлт гаргасан тохиолдолд 8 дахь өдөр дотроо илгээх ёстой. Хаагдсан орогнол хүсэх өргөдлийг дахин нээлгэх хүсэлтийг 3.3-аас үзэх. Хаагдсан орогнол хүсэх өргөдлийг дахин хянуулах хүсэлтийг 3.4-өөс үзэх). Орогнол хүсэх эрхийн гэрчилгээ өгнө .

Өргөдлөө зөвхөн шуудангаар, дараах хаягаар илгээсэн байх:

OFPRA  
201, rue Carnot  
94 136 FONTENAY-SOUS-BOIS CEDEX

Жишээлбэл, хэрэв орогнол хүсэх эрхийн гэрчилгээ тань 1-р сарын 10-нд гарсан бол та 1-р сарын 31-ний өдрөөс хэтрэхгүй хугацаанд OFPRA-д хавтаст хэргээ илгээсэн байх ёстой. Үүнийг шуудангийн тамга нотлох болно.

Хавтаст хэргээ "хүлээн авах баримттай баталгаат захидлаар" мөн түүнчлэн "илгээгчийн" хэсэгт өөрийн нэрийг гаргацтай бичиж илгээхийг хатуу сануулж байна.

Хэрэв таны хавтаст хэрэг гүйцэд бүрдээгүй бол, түүнийг OFPRA танд буцаан илгээх бөгөөд гүйцэд бүрдүүлэн илгээх нэмэлт 8 хоног олгох болно (хэрэв дахин нээлгэх эсбол дахин хянуулах бол 4 хоног). Хэрэв та энэ хугацаанд хавтаст хэргээ дахин илгээгээгүй бол OFPRA таны хүсэлтийг хааж тухайн нутаг дэвсгэрт байх эрх тань дуусгавар болох бөгөөд орогнол хүсэх эрхийн гэрчилгээ тань дахин шинэчлэгдэхгүй болно.

Та процедурынхаа явцад, хүссэн үедээ, OFPRA-д нэмэлт элементүүдээ захидлаар илгээж болно. OFPRA-д хандан илгээсэн, мөн тус албаас авсан хүлээн авсан бүх захидлын хуулбар, мөн шуудангаар илгээсэн буюу хүлээн авсан тухай бүх нотлох баримтыг сайтар хадгална уу.

OFPRA-руу илгээсэн захидал бүрт тус албаас ирүүлэх орогнолын өргөдөл оруулсан тухай эхний тайлбар захидал дээр бичигдсэн хавтаст хэргийн дугаараа заахаа бүү мартаарай.

### Та процедурынхаа явцад хаягаа өөрчилсөн үү ?

Хэрэв та байрлаж байгаа газрынхаа хаягийг OFPRA-д мэдээлсэн бөгөөд тэр нь таны оршин суудаг хаягаас ялгаатай бол, мөн түүнчлэн хэрэв байраа өөрчилсөн бол, OFPRA-тай холбоо барьж аль болох даруй мэдэгдэх шаардлагатай ба, энэ зорилгоор ([www.ofpra.gouv.fr](http://www.ofpra.gouv.fr)) OFPRA-ийн вэбсайтад байрлах "Démarques en ligne" гарчигтай теле-үйлчилгээг ашиглан дамжуулах боломжтой. Учир нь хамгийн сүүлд мэдээлсэн хаягаар OFPRA захидалуудаа илгээх бөгөөд, үүнд ярилцлагт оролцох дуудлага эсбол таны орогнолын өргөдөлд гаргасан шийдвэр зэргийг илгээх болно.

Хэрэв та өөрийн эзэмшсэн эсбол түрээслэсэн орон сууцанд амьдардаг бол, эсбол эхнэр / нөхөр / хүүхэд / асран хамгаалагчийнхаа байранд амьдардаг бол, хаягаа өөрчилсөн тохиолдолд, OFII-д энэ талаар мэдэгдэх үүрэгтэй.

## ■ OFPRA-д өргөдөл гаргасан тухай нотлох баримт.





Таны хавтаст хэрэг бүрдсэн бөгөөд, хугацаанд нь багтаан ирүүлсэн тохиолдолд, OFPRA нь өргөдлийг тань тус алба хүлээн авч хэргийн дугаар олгосон тухай мэдээлж холбогдох захидлыг илгээнэ.

Энэхүү баримт бичиг нь таны орогнол хүссэн өргөдлийг OFPRA-д оруулсан тухай албан ёсны нотлох баримт болох юм.

Энэхүү баримт бичиг нь анхны орогнол хүсэх эрхийн гэрчилгээг сунгах боломжийг олгоно (2.2.1.-рт "Орогнол хүсэх эрхийн гэрчилгээ олгох" -г үзнэ үү).

Голчлон, ярилцлагын зарлан дуудах бичгийг танилцуулгын захидалтай хамт илгээдэг болно. Энэхүү ярилцлагын зарлан дуудах бичиг нь танилцуулгын захидлын ар талд гарч ирнэ. Хэрэв зарлан дуудах бичиг нь танилцуулах захидлын ар талд гарч ирээгүй бол дараа тусдаа захидлаар илгээх болно.

### ■ Өргөдөлийг шалган үзэх ердийн журам эсхүүл хурдасгасан журам

Таны орогнолын хүсэлтийг OFPRA ердийн, эсбол хурдасгасан журмаар шалган үзэх болно.

2.2.1-рт заасны дагуу (Орогнолын тань өргөдлийг тодорхойлох-ыг үзэх), хурдасгасан журмын хугацааг 15 хоног хүртэл богиносгосон ч ердийн журмаас ялгаагүй үйл ажиллагааны баталгаа ижил байна. Таны орогнолын хүсэлтийг Нэгдсэн хүлээн авах цонхонд бүртгэхдээ хурдасгасан журамд хамруулсан бол OFPRA таны өргөдлийг хурдасгасан журмаар шалгах болно. Гэсэн ч, хэрэв та нутаг дэвсгэрт байснаар нийтийн хэв журам, нийгмийн болон үндэсний аюулгүй байдалд ноцтой аюул занал учруулаагүй бол OFPRA нь таны хавтаст хэргээс шалтгаалан, мөн түүнчлэн хувийн онцгой нөхцөл байдлыг харгалзан, шаардлагатай гэж үзвэл, ердийн журамд оруулах хүсэлтийг тань хүлээн авч дахин ангилах боломжтой.

Түүнчлэн OFPRA нь дараах тохиолдолуудад хурдасгасан журамаар тодорхойлох шийдвэр гаргаж болно:

- хэрэв та OFPRA-г төөрөгдөлд оруулхыг завдан хуурамч бичиг баримт бүрдүүлэн, худал мэдүүлгээр хангаж эсхүүл зарим мэдээлэл, бичиг баримтыг нуун дарагдуулсан бол;
- хэрэв та олон өөр овог нэрээр хэд хэдэн өргөдөл гаргасан бол;
- та орогнол хүссэн өргөдөлдөө орогногчийн хамгаалал олгох шаардлагатай бус асуудлаар хүсэлт гаргасан болно ;
- Таны мэдэгдлүүд хоорондоо авцалдаагүй, зөрчилтэй, илт хуурамч, үнэмшилгүй, түүнчлэн таны эх орны талаархи мэдээлэл тус албын мэддэг зүйлтэй зөрчилдөж буй бол.

Хэрэв таны өргөдлийг хурдасгасан журамд хамруулсныг эсэргүүцхээр бол та зөвхөн CNDA- д давж заалдах үед л илэрхийлж болно.

### ■ OFPRA-ийн биечилсэн ярилцлага.

Таны өргөдлийг OFPRA-д хүргэсний дараа та ярилцлагын дуудлага хүлээн авна.


Та зөвхөн дурдсан хоёр тохиолдолд ярилцлагаас чөлөөлөгдөж болно :

- таны хавтаст хэрэгтээ оруулсан мэдээллүүд OFPRA-ийн хувьд танд орогногчийн статус олгоход хангалттай бол;
- таны эрхшээлээс үл хамааран, эрүүл мэндийн удаан хугацааны шалтгаан нь, ярилцлагад хүрэлцэн очих буюу оролцох боломжгүй болгосон бол.

Хэрэв та ярилцлагад дуудагдсан бол Фонтеней-Су-Буа дахь OFPRA-ийн төв байранд хүрэлцэн очих үүрэгтэй болно. Таныг "хамгааллын байцаагч" гэх OFPRA-ийн ажилтанд асуугдах бөгөөд, шаардлагатай тохиолдолд OFPRA-аас бэлтгэсэн орчуулагч нь, анх орогнолын хүсэлтээ бүртгүүлэх үе шатад Нэгдсэн хүлээн авах цонхноо сонгосон тэр хэлээр ярилцах болно. Эсбол таны хангалттай мэдлэгтэй нэгэн хэл дээр явагдах болно (2.2.1-рт " OFPRA -дээр хийх ярилцлагын хэл сонгох"







хэсгийг үзнэ үү). Гэсэн хэдий ч, та хүссэн үедээ франц хэлдээр асуугдхыг хүсч болно. Та ярилцлагт ашигласан хэлний тухай маргааныг зөвхөн CNDA-д давж заалдах үедээ л үүсгэж болно.

**Хэрэв та энэ ярилцлагт биеэр хүрэлцэн очоогүй бол оролцоогүй байдал тань OFPRA-ийн зүгээс завхөн таны өргөдөл дээр үндэслэх эсбол хэргийг хаах зэрэг шийдвэр гаргахад хүргэж болзошгүй юм.** Тиймээс саад гарсан тохиолдолд дор хаяж 48 цагийн өмнө OFPRA-д урьдчилан мэдэгдэх, эсбол ямар нэг саатал гарсан тухайгаа дуудлага дээр заасан хаягаар захидлаар мэдэгдэх шаардлагатай.

Хэрэв та хүсвэл, тус ярилцлагт нэгэн өмгөөлөгчийн эсбол OFPRA-ийн зөвшөөрөгдсөн нэгэн нийгэмлэгийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хамт оролцож болох бөгөөд, тэр нь ярилцлагын төгсгөлд ажиглалтаа илэрхийлэх боломжтой. Гэхдээ өмгөөлөгч эсбол нийгэмлэгийн төлөөлөгч уг дуудлагт цагтаа багтаж хүрэлцэн ирээгүй шалтгаанаар ярилцлагыг хойшлуулахгүй. Хэрэв та хөгжлийн бэрхшээлтэй бол, ярилцлага өгөхдөө таныг байнга хяналтандаа мөрддөг нэгэн эрүүл мэндийн ажилтан эсбол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбооны нэгэн төлөөлөгчийг хамт байлцуулж оролцох зөвшөөрлийг хүсэж болно.

Хэрэв та хүсвэл, өргөдлийнхөө ноцтой шалтгааныг тайлбарлах хүндрэл танд гарах тохиолдолд, ялангуяа бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлын талаар бол, ярилцлага таны сонгосон хүйсийн OFPRA-ийн төлөөлөгч ба / эсбол орчуулагчтай явуулж болно. Энэ талаар та ярилцлагын өдрөөс урьтан OFPRA-аас хүсч болно.

**Ярилцлага нууц байна.** Таны мэдэгдлүүдийг ярилцлага явуулсан хамгааллын байцаагчийн бичсэн тайланд тэмдэглэх бөгөөд, үүнийг хэрэв та хүсэлт гаргасан тохиолдолд (ердийн журмаар бол) шийдвэр гарахаас өмнө, эсбол (хурдасгасан журмаар бол) хамгийн цаад хугацаа, шийдвэрийн хамт танд хүргэж болно.

Энэхүү ярилцлагыг дуун бичлэгтэй явуулах ба үүнд та зөвхөн OFPRA-аас татгалзсан шийдвэр гарсан тохиолдолд болон уг шийдвэрийг давж заалдах зорилгоор л нэвтрэх боломжтой.

#### Та Фортеней-су-Буа дахь OFPRA-ийн төв байрнаас өөр газар асуугдаж болох уу?

Таны ярилцлага нь, газарзүйн алслагдмал байдлаас (ялангуяа гадаад далайн чанад газар байгаа бол) эсбол таны хувийн нөхцөл байдлаас шалтгаалан (эрүүл мэнд ба гэр бүлийн шалтгаанаар аялах боломжгүй бол, мөн түүнчлэн хэрэв таны эрх чөлөөг хязгааралсан газар хоригдож байгаа бол) Фонтеней-су-Буа-д биш харин холын зайнаас, дуу, дүрс бичлэгийн хэрэгслийн аргаар явагдах болно.

Энэ тохиолдолд, шаардлагатай бол, танд дэмжлэг үзүүлдэг нэгэн өмгөөлөгч эсбол нийгэмлэгийн нэгэн төлөөлөгч таны дэргэд байх болно. Орчуулагч нь хамгааллын байцаагчтай хамт байх болно.

Хэрэв та далайн чанад нутаг дэвсгэрт эсбол зарим метрополитены нутаг дэвсгэрт байдаг бол, та OFPRA-ийн ажилтанд асуугдаж болох ба, тэр тусмаа Гвинегийн департаментад амьдардаг бол, Кайенна дахь OFPRA-ийн салбарын төлөөлөгчид шууд асуугдаж болно, бусад нутаг дэвсгэрт OFPRA-ийн сургалтын үйл ажиллагааны үеэр боломжтой.

#### ■ Эрүүл мэндийн үзлэг.

OFPRA-ийг зүгээс эрүүл мэндийн үзлэгт хамрагдахыг шаардаж болно. Уг эрүүл мэндийн үзлэгт хамрагдахаас татгалзсах нь таны өргөдлийг бүрэн бусд тооцход хүргэхгүй бөгөөд OFPRA шийдвэрээ гаргахад саад болохгүй юм. Хэрэв та насанд хүрээгүй ба бэлэг эрхтний гэмтэлтэй холбогдох эрсдэл нүүрэлсэн шалтгаанаар орогнолын өргөдөл гаргасан бол, OFPRA нь энэхүү эрүүл мэндийн үзлэгийн санхүүжилтыг хариуцна.





Эрүүл мэндийн тодорхойлолтыг эмчээс OFPRA-д шууд дамжуулах бөгөөд, түүний нэг хуулбарыг таны эцэг эхийн, эсбол хууль ёсны хариуцагчийн гар дээр тавих болно.

## ■ OFPRA-ийн шийдвэр.

### ✓ Хугацаа

OFPRA-ийн шийдвэр ирэх хугацаа нь харилцан адилгүй : хурдасгасан журамд хамрагдсан тохиолдолд дунджаар 15 хоног, ердийн журмаар бол хэдэн сар хүртэл хугацаа болно. OFPRA-аас удаан хугацаагаар сураг өгөхгүй байх нь таны гүйлтийг татгалзсан гэсэн үг биш. Хэрэв OFPRA таны гүйлтанд 6 сарын дотор хариу өгч чадахгүй тохиолдолд энэ тухай танд захиагаар мэдэгдэнэ. Ингэсэн тохиолдолд та захидлаа байнга шалгаж байх үүрэгтэй болно.

### ✓ Таатай шийдвэр (1-р хэсэгт « Орогногчийн статусын төрлүүд » -ийг үзнэ үү)

Хэрэв та таатай шийдвэр хүртсэн бол, таныг :

- **Нэг бол, орогногчоор хүлээн зөвшөөрч**, OFPRA танд орогногчийн статус олгосон шийдвэр хүргүүлнэ ;
- **Нэг бол, субсидиар хамгаалал хүртэхийг зөвшөөрч**, OFPRA танд субсидиар хамгаалал олгосон шийдвэр хүргүүлэхийн зэрэгцээ хамгааллын статусаа захиргааны байгууллагуудад нотлох захидал өгөх болно.

### ✓ Таагүй шийдвэр

OFPRA нь таны орогнолын хүсэлтийг татгалзсан гурван төрлийн таагүй шийдвэр гаргаж болно :

- **татгалзсан шийдвэр ;**

Энэхүү шийдвэрийг та CNDA –ийн өмнө давж заалдаж болно. Орогнолын шалтгаанаар нутаг дэвсгэрт байх эрхийн тухай, түүний нөхцөл байдлын талаар та «OFPRA-ийн шийдвэрийг мэдүүлсний дараа нутаг дэвсгэрт байх эрхийн дуусгавар » гарчигийг 3.1.-рт үзнэ үү.

- **Хүлээн зөвшөөрөхгүй шийдвэрийг** дараах нөхцөлд гаргана :
  - Та Европын холбооны гишүүн болох нэгэн Улсын орогнолын хүчин төгөлдөр бүхий хамгаалал хүртсэн байх;
  - Та нэгэн гуравдагч орны орогногчийн эсбол хамгааллын хүчин төгөлдөр статус хүртсэн эсбол түүнийг дахин сэргээх боломжтой бол.

Та энэхүү шийдвэрийг CNDA-ийн өмнө даван заалдаж болно. Та CNDA-ийн өмнө даван заалдаж буй ч, орогнолын шалтгаанаар нутаг дэвсгэрт байх эрхийг эдлэх боломжгүй болно («OFPRA-ийн шийдвэрийг мэдүүлсний дараа нутаг дэвсгэрт байх эрхийн дуусгавар » гарчигийг 3.1.-рт үзнэ үү.).

- **Хэргийг хаах шийдвэрийг** дараах нөхцөлд гаргана :
  - та OFPRA-д орогнолынхоо хүсэлтийг татан буулгах тухай ярилцлагын явцад эсбол захидлаар мэдэгдсэн бол ;
  - та орогнолын өргөдлөө 21 хоногийн хугацаанд оруулаагүй эсбол та ярилцлагт биеэр хүрэлцэн орлоогүй бол;
  - таны хэргийг шалгах үндсэн мэдээллүүдийг гаргаж өгөхөөс санаатайгаар татгалзаж буй бол;
  - хаягаа хүргүүлээгүй улмаас, зохих хугацаанд тантай холбогдох боломжгүй бол.
  - Таны өргөдөл Нэгдсэн хүлээн авах цонхонд бүртгэгдсэн ч, хууль ёсны шалтгаангүйгээр, та хавтаст хэргээ OFPRA-д илгээгээгүй бол.

Та энэхүү шийдвэрийг CNDA-ийн өмнө биш, харин захиргааны шүүхийн өмнө давж заалдаж болно. Та орогнолын шалтгаанаар нутаг дэвсгэрт байх эрхийг эдлэх боломжгүй болно («OFPRA-





ийн шийдвэрийг мэдүүлсний дараа нутаг дэвсгэрт байх эрхийн дуусгавар » гарчигийг 3.1.-рт үзнэ үү.). Танд хэргийг хаах тухай шийдвэр мэдэгдсэнээс хойш 9 сарын дотор дахин нээлгэх хүсэлт гаргаж болно (3.3-р хэсгийг үзнэ үү).

#### ✓ **ОFPRA-ийн шийдвэр илгээх нөхцөлүүд**

**ОFPRA** нь шийдвэрээ франц хэл дээр бичиж илгээх бөгөөд, мөн таны ойлгодог гэж үзэх үндэслэлтэй нэгэн хэл дээр орчуулсан баримт бичгийг илгээнэ. Үүндээ таны шийдвэрийн утга агуулгыг заасан байх бөгөөд энэ нь гуйлтыг татгалзсан тохиолдолд юм.

#### **ОFPRA таны орогнол хүсэх хүсэлтийг танилцуулсан захидал явуулж, биечлэн ярилцлаганд урьж, гаргасан шийдвэрээ материаллаг бус аргаар мэдэгдэх боломжтой юу?**

ОFPRA орогнол хүсэх хүсэлтийг танилцуулсан захидал явуулж, биечлэн өгөх ярилцлаганд урьж, гаргасан шийдвэрээ хувийн хаяг руу тань материаллаг бус аргаар явуулахаар зохицуулан боловсруулсан.. Энэ үйл явц нь орогнол хүссэн өргөдлийн нууцлалыг бүрэн хангах болно.

Энэ үйл явцыг хэрэгжүүлэх болсон тохиолдолд танд орогнолын хүсэх өргөдлийг тань бүртгэх үед эсхүл “Дублин”-ы процедурын 2.2.1-т заагдсаны дагуу таны орогнол хүсэх үйл явц Францын талд шилжүүлэх үед бүрэн дуусаагүй байх үед мэдэгдэх болно. Энэ үйл явцыг хэрхэн хэрэгжүүлэх арга байдлын мэдэгдлийг танд тухайн үед нь өгнө.

#### ■ **ОFPRA-ийн шийдвэрийг даван заалдах.**

Та мэдэгдэл авсан өдрөөс хойш нэг сарын дотор CNDA-ийн өмнө OFPRA-ийн шийдвэрийг эсэргүүцэж болно (3.2-рт "CNDA-аар шалгуулах" хэсгийг үзнэ үү). Хэрэв та CNDA-д давж заалдаагүй, эсхүл илтээр хугацааг нэг сараас нь хэтрүүлэн давж заалдсан бол, тухайн нутаг дэвсгэрт байх эрх тань дуусгавар болж, орогнол хүсэх эрхийн гэрчилгээ тань татан хураагдахад хүргэж эсбол шинэчлэгдэхгүй тул та Франц улсыг орхин гарах болно.

Хэрэв та CNDA-д давж заалдах зорилгоор хууль эрх зүйн туслалцааг хүртхийг хүсч байгаа бол OFPRA-ийн шийдвэр мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор уг хүсэлтийг гаргах ёстой. Энэ тохиолдолд, давж заалдах нэг сарын хугацаа нь тасалдаж, хууль зүйн туслалцаа авах өргөдлийн шийдвэрийг танд мэдэгдсэн өдрөөс хойш үлдсэн хугацаа нь дахин үргэлжилж эхлэх болно (3.2-рт "өмгөөлөгчийн туслалцаа авах" хэсгийг үзнэ үү).

CNDA-ийн шийдвэрийг Төрийн зөвлөлд нэг бол та өөрийн биеэр нэг бол OFPRA давж заалдаж болно.

#### ■ **ОFPRA-ийн шийдвэр мэдэгдсний дараа нутаг дэвсгэрт байх эрхийн дуусгавар.**

Зарчмын хувьд, таны орогнолын өргөдлийг шалгах нийт хугацаанд, тэр дундаа давж заалдах хуулийн үйл ажиллагааг тооцон, та нутаг дэвсгэрт үлдэх эрхтэй.

Гэсэн хэдий ч, та дараах OFPRA-ийн шийдвэрүүдийн аль нэгийг хөндсөн тохиолдолд таны нутаг дэвсгэрт үлдэх эрх тань дуусгавар болно :

1. хүлээн зөвшөөрөхгүй шийдвэр, та нэгэн өөр Улсын хүчин төгөлдөр хамгаалал хүртсэн ба тэр Улс нь ЕХ-ы гишүүн бус байх бөгөөд танд дахин сэргээх боломжтой бол (3.3-ыг үзэх);
2. хэрэг хаах шийдвэр (3.3-ыг үзэх);





3. та аюулгүй улсын иргэншилтэй болох үндэслэлээр орогнолын өргөдөл нь хурдасгасан журамд хамрагдаж, татгалзсан шийдвэр авсан;
4. Улсын нутаг дэвсгэрт байх нь олон нийтийн дэг журамд ноцтой аюул учруулж буй тул орогнолын гуйлтыг хурдасгасан журамд хамруулж, татгалзсан шийдвэр авсан;
5. дахин хянуулах хүсэлт нь зөвшөөрөгдсөн, татгалзсан шийдвэр авсан;
6. дахин хянуулах анхны хүсэлтэнд хүлээн зөвшөөрөхгүй шийдвэр ноогдуулсан;
7. хүлээн зөвшөөрөхгүй, эсхүл татгалзсан шийдвэр, захиргааны болон шүүхийн шийдвэрээр нутаг дэвсгэрээс хөөгдсөн эсбол хоригтой, эсбол гэрийн хорионд, захиргааны саатуулганд байрлуулсан бол (2.2.1-рт " Та албадан холдуулах захирамж, захиргаа эсбол шүүхээс нутаг дэвсгэрийн хориг тавьсан шийдвэртэй юу? " хэсгийг үзэх).

Эдгээр тохиолдолд орогнол хүсэх эрхийн гэрчилгээг хураан авах эсбол сунгахгүй бөгөөд Францын нутаг дэвсгэрээс гарах үүргийг таны эсрэг ноогдуулах боломжтой (5-р хэсгийг үзэх).

## 3.2. Орогнолын эрх олгох Үндэсний шүүхээр шалгуулах (CNDA).

### ■ Даван заалдах хугацаа.

Та CNDA-д хандан даван заалдах өргөдөл гаргахад OFPRA-ийн татгалзсан мэдэгдлээс хойш нэг сарын хугацаатай. Та дараахийг хийж болно:

- OFPRA –с гаргасан хүлээн авашгүй, эсхүл татгалзсан шийдвэрийг Шүүхээс хүчингүй болгож, хамгаалалт өгөхийг хүсэх;
- танд субсидиар хамгаалал олгох шийдвэр гарсан тохиолдолд орогногчийн статус хүлээн зөвшөөрөхийг хүсэх. Энэ тохиолдолд, хэрэв CNDA таныг орогногчоор хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд, та субсидиар хамгаалалтын ашиг тус, түүнтэй холбоотой эрх ашгийг хадгалах болно (6-р хэсэгт « Хамгаалал хүртэгсэдийн эрхүүд »-ийг үзэх). Нэмж дурдахад, CNDA нь таныг орогногчоор хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд OFPRA-аас өмнө нь авсан субсидиар хамгаалалтын тусламжийг буцаах боломжгүй.

Энэхүү давж заалдах өргөдөл нь нэг сарын хугацаа дуусахаас өмнө CNDA-д хүрэх ёстой (жишээлбэл, хэрэв та 1-р сарын 20-ны өдөр албан татгалзсан шийдвэрээ шуудангаас хүлээн авсан бол, таны давж заалдах хүсэлтийг хамгийн цаад хугацаа 2 сарын 21-ний шөнө дундаас өмнө CNDA дээр хүлээн авсан байх ёстой). CNDA-ийн өмнө давж заалдах хүсэлтийг хүлээн авсан тухай баримттай баталгаат захидлаар, эсбол энгийн захидлаар мөн түүнчлэн факсаар илгээсэн байх. Иймээс таны давж заалдах хүсэлт нэг сарын хугацаа дуусахаас өмнө, факсаар илгээсэн бол шөнө дундаас өмнө илгээсэн байх ёстой. Хэрэв таны давж заалдах өргөдөл шүүхийн өмнө хүлээн авах үед нэг сарын хугацаа хэтэрсэн бол хүлээн зөвшөөрөхгүй гэж үзнэ, өөрөөр хэлбэл шүүх хурлаар хэлэлцэлгүй мөн шалгалгүйгээр татгалзах болно.


### ■ Өмгөөлөгчийн тусалцаа.

Та CNDA-д давж заалдах өргөдөл гаргахдаа болон шүүх хурлаар орохдоо өмгөөлөгч авах боломжтой. Үүний тулд та хууль эрх зүйн туслалцаа авах өргөдөл гаргаж болно. Өмгөөлөгчийн төлбөрийг улсаас бүрэн даах бөгөөд өмгөөлөгч нь танаас үйлчилгээний төлбөр нэхэмжлэх эрхгүй болно.

Хууль эрх зүйн туслалцаа авах өргөдөл гаргахын тулд та OFPRA-ийн татгалзсан шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор, CNDA-ийн хууль зүйн туслалцааны албанд хандаж холбоо барих шаардлагатай.

CNDA-ийн хууль зүйн туслалцааны алба ([BAJ](#)) –ын :





Cour nationale du droit d'asile  
35, rue Cuvier  
93 558 MONTREUIL-SOUS-BOIS

Хууль зүйн туслалцааны хүрээнд таныг өмгөөлөхийг зөвшөөрөх өмгөөлөгчийн нэрийг та өөрөө заах юм уу CNDA-аас өмгөөлөгчийн нэр томилохыг хүсэж болно. Хэрэв та хууль эрх зүйн туслалцаа хүртэж байгаа бол тэр томилсон өмгөөлөгчийн үйлчилгээний төлбөрийг, тэр нь танаас нэхсэн ч төлөх ёсгүй.

Таны давж заалдах өргөдлийг илт хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд л хууль эрх зүйн туслалцаа авах хүсэлтийг тань татгалзаж болно.

Хууль эрх зүйн туслалцаа авах өргөдлийг тань шалгах зуур, хэрэв хүсэлтээ 15 хоногийн дотор гаргасан тохиолдолд CNDA-д өргөдөл гаргах хугацааг түр тасалдана. Энэ тохиолдолд, давж заалдах нэг сарын хугацаа нь тасалдаж, хууль зүйн туслалцаа авах өргөдлийн шийдвэрийг танд мэдэгдсэн өдрөөс хойш үлдсэн хугацаа нь дахин үргэлжилж эхлэх болно. Тиймээс танд CNDA-ийн өмнө давж заалдах гомдлоо өгөх шинэ хугацаа бий болох бөгөөд энэ нь OFPRA-ийн шийдвэрийн мэдэгдэл ба хууль зүйн туслалцаа авах хүсэлтийн хооронд үлдсэн өдрүүдийн тооноос бага байна.

Жишээлбэл, OFPRA 1-р сарын 15-нд татгалзсан шийдвэрээ мэдэгдвэл танд хууль эрх зүйн туслалцаа авах өргөдөл гаргахад 15 хоног байх болно. Хэрэв та 1-р сарын 20-ны өдөр Хууль зүйн туслалцаа үзүүлэх өргөдөл гаргасан бол OFPRA-ийн шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 5 хоногийн дараа, хууль эрх зүйн туслалцааны газрын шийдвэрээс 26 хоногийн дараа давж заалдах өргөдлөө гаргах болно.

#### ■ Даван заалдах.

Та дараах нөхцөлүүдийг дагаж мөрдөх үүрэгтэй :

- юуны өмнө, OFPRA-ийн татгалзсан шийдвэрийн ар талд байгаа бүх тайлбарыг унших;
- давж заалдах өргөдлийг франц хэл дээр ердийн цаасан дээр бичсэн байх (тодорхой хэлбэр байхгүй), үүндээ овог, нэрээ, төрсөн он, сар, өдөр, иргэний харьяалал, оршин суугаа газрын хаягийг бичсэн байх ёстой.
- та давж заалдах өргөдөлдөө гарын үсгээ зурсан байх; хэрэв та насанд хүрээгүй бол хууль ёсны төлөөлөгч тань гарын үсэг зурах;
- та даван заалдах өргөдөлдөө OFPRA-ийн шийдвэрийн хуулбарыг хавсаргах;
- хэрэв таны орогнолын хүсэлтийг хурдасгасан журамд хамруулсан бол орогнолын өргөдлөө бүртгүүлэх үед олгосон мэдээллийн хуудсын хуулбарыг хавсаргах. (2.2.1-рт « Орогнолын тань өргөдлийг тодорхойлох» хэсгийг үзэх );
- Та давж заалдах шалтгаанаа зөвтгөх шаардлагатай. Өөрөөр хэлбэл OFPRA-ийн татгалзсан шалтгаан эсхүл OFPRA-аас танд орогногч биш субсидиар хамгаалал олгох болсон шийдвэрийг үл зөвшөөрөх шалтгаанаа тайлбарлах ;
- та өөрийн иргэний үнэмлэх, иргэний харьяаллыг баталгаажуулсан баримт бичгийг хавсаргах;
- түүнчлэн, та түүхээ гүйцэд бүрдүүлэх баримтуудыг хавсаргах ;
- Хэрэв та OFPRA-д асуугдсан хэлээ заргалдахыг хүсч байвал түүнийг давж заалдах өргөдөлдөө заавал зааж өгөх хэрэгтэй бөгөөд асуугдахыг хүсч буй хэлээ зааж өгөх ёстой. Хэрэв шүүх таны гаргасан заргыг хүлээн авсан бол, мөн таны хүссэн хэл дээр орчуулагч томилж чадахгүй бол, та ойлгодог нэгэн хэлээр асуугдах болно.
- та давж заалдах өргөдөл илгээсэн буюу хүлээлгэн өгсөн нотлох баримтаа, мөн түүний хуулбарыг хадгалах ёстой;
- та CNDA-д хаягийнхаа өөрчлөлтийн талаар мэдэгдэх ёстой;
- та давж заалдах өргөдлөө бүртгүүлсний дараа хавтаст хэргтэйгээ танилцахыг хүсч болно.





Иргэний харьяалалаа нотлох бичиг баримтын хувьд тэдгээрийн хуулбарыг хавтаст хэрэгтээ хавсаргаж, паспорт эсбол иргэний үнэмлэхнийхээ эх хувийг хадгалах нь зүйтэй. Эдгээр бичиг баримтаа өөртөө агуулснаар та CNDA-аас баталгаат захидлаар илгээсэн захидлуудыг хүлээн авах боломжтой байх болно. Шүүх бүрэлдхүүнээс шаардсан тохиолдолд та шүүх хуралдааны өдөр нь эх хувилбарыг танилцуулж болно.

Таны түүхийг нотлох баримт бичгийн хувьд та эх хувийг хавтаст хэрэгтээ хавсаргаж хуулбараа хадгалах нь зүйтэй юм. Эдгээр баримтуудыг шүүх хурлын өдөр, хэрэв та гуйвал, танд буцааж өгөх эсбол, дараа нь шуудангаар илгээж болно. Таны түүхийг нотлох баримт бичгүүдийг франц хэл рүү орчуулсан байх ёстой. Орчуулга байхгүй тохиолдолд CNDA нь тэдгээрийг ашиглах боломжгүй болно. Гэхдээ иргэний бичиг баримт, шүүх, цагдаагийн баримтаас бусад тохиолдолд орчуулгыг тангарагтай орчуулагч хийсэн байх албагүй.

Хэрэв та олон нийтэд нээлттэй шүүх хуралдаанд дуудагдсан бол нэмэлт мэдээлэлийг таны дуудлагт хязгааралсан хугацаанаас өмнө бичгээр өгч болно.

### ■ Давж заалдах хүсэлтийг хүлээн авсан тухай мэдэгдэл.

Таны давж заалдах хүсэлтийг бүртгэсний дараа CNDA нь таны заасан хаягаар "давж заалдах хүсэлтийг хүлээн авсан тухай мэдэгдэл" гэсэн баримт бичгийг хүргүүлнэ. Энэхүү баримт нь таны давж заалдах өргөдөл бүртгэгдсэнийг гэрчилнэ.

Онцгой тохиолдолоос бусад үед ("давж заалдахыг түдгэлзүүлэх шинж чанар" хэсгийг үзнэ үү) энэ баримт бичиг нь, CNDA-аас таны хүсэлтийг шийдэх хүртэл хугацаанд Францад байх эрхтэй тул, таны орогнол хүсэх эрхийн гэрчилгээг сунгах боломжийг олгоно.

### ■ Давж заалдахыг түдгэлзүүлэх шинж чанар.


**Ихэнхдээ, та CNDA –ийн өмнө OFPRA-ийн татгалзсан шийдвэрийн эсрэг давж заалдах эрхтэй бөгөөд энэхүү давж заалдах ажиллагаа автоматаар түдгэлзэх боломжтой бөгөөд** та давж заалдах хугацаа дуусах хүртэл, мөн давж заалдсан тохиолдолд шүүх шийдвэрээ гаргах хүртэл хугацаанд Францын газар нутагт байх эрхийг үргэлжлүүлэн эдлэх болно гэсэн үг юм.

**Нөгөө талаар, таны орогнолын хүсэлтийг эцсийн байдлаар татгалзхын өмнө, та Францын нутаг дэвсгэрт үлдэх эрхээ алдана** (3,1-рт OFPRA-ийн шийдвэр мэдэгдэсний дараа нутаг дэвсгэрт байх эрхийн дуусгавар " хэсгийг үзнэ үү), та OFPRA-г татгалзсан эсбол хүлээн зөвшөөрөхгүй гэсэн шийдвэрийн эсрэг **CNDA-д давж заалдах өргөдөл гаргах эрхээ хэвээр хадгалах** боловч энэ давж заалдах хүсэлтийг автоматаар түдгэлзүүлэхгүй болно:

- ✓ дор дурдсан шийдвэрүүдийн аль нэгэнд нь хамрагдсан тохиолдолд, **нэг бол таны давж заалдах хүсэлтийг түдгэлзүүлэхгүй** бөгөөд таны эсрэг албадан холдуулах шийдвэр гарч, түүнийг биелүүлэх болно :
  1. та нэгэн гуравдагч орны орогногчийн эсбол хамгааллын хүчин төгөлдөр статус хүртсэн бөгөөд тэр Улс нь ЕХ гишүүн бус улс бол таныг тус оронд шилжүүлэх боломжтой. (3.3-г үзэх);
  2. OFPRA-аас хэргийг хаах шийдвэр (3.3-г үзэх);
  3. дахин хянуулах анхны хүсэлтэнд хүлээн зөвшөөрөхгүй шийдвэр ноогдуулсан ба хүсэлтийг зөвхөн албадан холдуулах арга хэмжээнээс зайлс хийх зорилгоор гаргасан байх;
- ✓ дор дурдсан шийдвэрүүдийн аль нэгэнд нь хамрагдсан тохиолдолд, **нэг бол таны давж заалдах хүсэлтийг автоматаар түдгэлзүүлэхгүй, та захиргааны шүүхэд хандан CNDA-д давж заалдах хугацаанд, албадан холдуулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хүсч болно:**







1. таны харьяалал аюулгүй улсын гарал үүсэлтэйгээс үүдэн хурдасгасан журамд хамрагдаж OFPRA-аас татгалзсан шийдвэр авсан ;
2. та нутаг дэвсгэрт байснаар нийтийн хэв журамт байдалд ноцтой аюул занал үзүүлж буйгаас үүдэн хурдасгасан журамд хамрагдаж OFPRA-аас татгалзсан шийдвэр авсан ;
3. хүлээн зөвшөөрөхгүй дахин хянуулах өргөдөл тань OFPRA-аас татгалзсан шийдвэр авсан ;
4. албадан холдуулах арга хэмжээнээс зайлс хийх зорилгоор бус гаргасан дахин хянуулах өргөдөл тань OFPRA-аас хүлээн зөвшөөрөхгүй шийдвэр авсан;
5. Та захиргааны эсхүүл шүүхийн албадан холдуулах эсбол нутаг дэвсгэрийн хорио заасан захирамжинд хамрагдсан бөгөөд гэрийн хорио эсбол захиргааны саатуулганд орсон үед OFPRA-аас хүлээн зөвшөөрөхгүй эсбол татгалзсан шийдвэр авсан (2.2.1-рт «Та захиргааны эсхүүл шүүхийн албадан холдуулах эсбол нутаг дэвсгэрийн хорио заасан захирамжинд хамрагдсан уу? » хэсгийг үзэх).

Энэхүү түдгэлзүүлэлтийг та нэг бол, албадан гаргах арга хэмжээний эсрэг давж заалдах хүрээнд хүсэлт гаргаж, эсхүүл, орогнол хүсэх өргөдлөө гаргахаас тань өмнө энэхүү албадан гаргах арга хэмжээнд хамруулсан шийдвэрийг танд мэдэгдсэн болох, гэтэл үүний эсрэг давж заалдах боломжгүй бол, та түүнчлэн таныг гэрийн хорионд эсбол захиргааны саатуулах төвд байрлуулснаас хойш 48 цагийн дотор хүсэлтээ гаргаж болно.

#### ■ CNDA-ийн шүүх хуралдаан.

CNDA нь таны даван заалдалтыг хянах зорилгоор шүүх хуралдаанд дуудах болно.

Зарлан дуудах хуудас нь танд шүүх хуралдаан болохоос дор хаяж 1 сарын өмнө шуудангаар очих ба гэхдээ таны даван заалдалтыг хурдатгасан журамаар авч үзэх тохиолдолд шүүх хурлаас 15 хоногийн өмнө дуудах болно.

Гэхдээ OFPRA-аас гаргасан шийдвэрт эргэлзээ төрүүлэхүйц ноцтой элемент таны даван заалдах агуулаагүй бол, CNDA таны хэргийг илтгэгчээрээ хянуулсны дараа, шүүх хуралдаанд оролцуулахгүйгээр давж заалдах хүсэлтийг тань шүүд хэрэгсэхгүй болгож болно.

Энэ нөхцлөөс гадна, шүүх хуралдаан дурдсан газар явагдана:

- Монтрёй-д байрлах CNDA-ийн байранд, эсбол Палай де Жүстис-т (Иль де ла Сите-д);
- нэг бол, хууль зүйн яаманд хамааралтай нэгэн байрнаас хийх тохиолдолд видео-хуралдаанаар. Видео-хуралдааны нууцлалын болон дамжуулалтын чанарын баталгаа надвартай байх болно.

#### ✓ Шүүгчийн бүрэлдэхүүн :

Таны давж заалдах хүсэлтийг хянан шүүх CNDA-ийн шүүгчийн бүрэлдэхүүнийг нэгэн магистрат тэргүүлнэ. Үүнд НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд-Комиссарын тушаалаар томилогдсон нэгэн мэргэжилтэн оролцоно. Шүүгчийн бүрэлдэхүүн таны орогнолын өргөдөл дээр дүн шинжилгээ хийсэн илтгэгчийг сонссоны дараа, өмнө гарсан шийдвэр, таны болон, хэрэв өмгөөлөгчтэй бол түүний тайлбар зэргүүдийн утгыг үл харгалзан, давж заалдах хүсэлтэнд тань шийдвэр гаргана. OFPRA-ийн зүгээс хурдасгасан журмаар эсбол таны хүсэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэдэг шийдвэр гаргасан тохиолдолд CNDA таван долоо хоногийн дотор таны давж заалдах хүсэлтийг гол шүүгчээр шийдвэрлүүлнэ.


Шүүх нь өөрийн санаачилгаар эсбол таны хүсэлтээр коллегийн бүрэлдэхүүн үүсгэж шийдвэрлэх боломжтой ба энэ нь хэрэв таны орогнолын хүсэлт хурдасгасан журамд, эсбол хүлээн зөвшөөрөх боломжгүй ангилалд нийцэхгүй байх мөн түүнчлэн ноцтой хүндрэл гарсан гэж үзсэн тохиолдолд юм.

#### ✓ Орчуулгын үйл ажиллагаа :

CNDA нь та анх орогнолын өргөдлөө гаргахдаа сонгосон тэр хэлний орчуулагчаар хангахыг анхаарах бөгөөд (" OFPRA-ийн ярилцлагын хэл сонгох " -г үзнэ үү) хэрэв боломжгүй бол, таны







хангалттай мэдлэгтэй нэгэн хэл дээр явагдах болно. Хэрэв та OFPRA-дээр гарсан орчуулгын ямар нэгэн дутагдлыг анхааруулах шаардлагатай бол үүнийг CNDA-д давж заалдах үед гаргах боломжтой. Таны шүүх хуралдаан дуу, дүрс бичлэгийн хэрэгслээр явагдаж буй тохиолдолд, орчуулагч нь таны хажууд, асуугдаж буй байранд байх болно. Хэрэв тантай өөрийн биеэр байлцах орчуулагчийг олход хүндрэлтэй болох нь тогтоогдвол, шүүх хуралдааныг, тухайн орчуулагч танхимд байгаа эсэхийг шалган тогтоохоос нааш хуралдуулахгүй болно.

✓ **Таны ирц шүүх хуралдаанд :**

Шүүх хуралдаанд хүрэлцэн ирэхийг танд албан ёсоор зөвлөж байна. Хэрэв саад тотгор, хоцролт гарсан тохиолдолд CNDA-д урьдчилан мэдэгдэх шаардлагатай. Хэрэв та шүүх хуралдаанд биеэр оролцох боломжгүй бол, ирэх боломжгүй шалтгаанаа бичгээр тайлбарлан хугацаа хойшлуулах хүсэлт гаргаж болно. Хойшлуулах нь эрх зүйн эрх биш бөгөөд зөвхөн CNDA-гийн шүүгчдийн бүрэлдхүүний тэргүүлэгч л таны шүүх хуралдааныг өөр өдөр хойшлуулах боломжийг дангаараа шийднэ.

✓ **Шүүх хуралдааны олон нийтэд нээлттэй шинж чанар:**

Шүүх хуралдаан нь олон нийтэд нээлттэй. Гэсэн хэдий ч та шүүгчийн бүрэлдхүүний тэргүүлэгчээс хаалттай хуралдаан хүсч болно, өөрөөр хэлбэл таны хэргийг шалгахдаа нийтийг байлцуулахгүй юм. Энэ тохиолдолд хаалттай хуралдаан хийх зөвшөөрлийг олгоно. Тэргүүлэгч шүүгч мөн уг шийдвэрийг гаргаж болно.

## ■ CNDA-ийн шийдвэр.

Шийдвэрээ гаргасны араас, CNDA нь танд уг шийдвэрийг «хүлээн авалтын баримттай баталгаатай захиагаар» явуулна.

Уг шийдвэр франц хэл дээр байх буюу таныг ойлгодог гэх үндэслэлтэй нэгэн хэл дээр, шийдвэрийн утгыг тайлбарласан баримтын хамт явуулна.

Уг шийдвэртээ CNDA нь :

- OFPRA-ийн татгалзсан шийдвэрийг хүчингүй болгож орогногчийн статус эсбол субсидиар хамгаалал олгох. Ингэснээр та OFPRA-ийн хоёр хамгааллын аль нэгийг хүлээн зөвшөөрсөнтэй адил эрх эдэлнэ;
- OFPRA-ийн субсидиар хамгаалал олгох шийдвэрийг хүчингүй болгож орогногчийн статус олгох;
- OFPRA-ийн татгалзсан шийдвэрийг зөвтгөж, давж заалдах хүсэлтийг татгалзах ;
- Зарим тохиолдолд OFPRA-ийн шийдвэрийг хүчингүй болгож таны хүсэлтийг дахин хянуулах шийдвэр гаргах.

CNDA-ийн шийдвэрийг Төрийн зөвлөлийн Дээд шүүхийн өмнө давж заалдаж болно. Энэ нь таны нийт өргөдлийг дахин хянаж шүүхгүй зөвхөн хууль зүйн тодорхой асуудлуудыг хэлэлцэх болно. Энэ үйл ажиллагаа нь удаан хугацаанд үргэлжлэх бөгөөд мэргэшсэн өмгөөлөгч шаардана. Түүнчлэн хууль эрх зүйн туслалцаа авах хүсэлт гаргаж болно. Уг шүүхэд хандаснаар Франц улсад оршин суух зөвшөөрлөө сунгуулах эрх олгогдохгүй бөгөөд эх нутагруу тань албадан буцаахад саад болохгүй . Энэхүү үйл ажиллагааны талаар холбогдох нийгэмлэг болон өмгөөлөгчөөс зөвлөгөө авна уу.

## ■ CNDA-ийн шийдвэр гарснаас хойш үлдэх эрхийн дуусгавар.

Нутаг дэвсгэрт байх эрхийн дуусгавар нь :





- CNDA-ийн шийдвэрийг танилцуулсан буюу нээлттэй шүүх хуралдаанд сонсуулсан байх. Бүх тохиолдолд уг шийдвэрийг танд бичгээр мэдэгдэх болно;

- CNDA-ийн шийдвэрийг захирамжаар гаргасан бол бичгээр мэдэгдсэн байх.

Нутаг дэвсгэрт байх эрх тань дүүсгавар болсны дараа та Францыг орхин гарах үүрэгтэй бөгөөд танд Францын нутаг дэвсгэрээс гарах албадан үүрэг ноогдуулж болно. (5-р хэсгийг үзэх).

### 3.3. Хаагдсан орогнолын өргөдлийг дахин нээх.

Таны орогнолын хавтаст хэргийг хаасан тохиолдолд та хэрэг хаасан шийдвэрээс 9 сарын хугацаанд хэргээ дахин нээлгэх хүсэлт зөвхөн нэг л удаа гаргаж болно. (3,1-рт « OFPRA-ийн шийдвэр » үзнэ үү. Үүний тулд та орогнол хүсэгчдийг анхлан хүлээн авах бүтэц (SPADA) дээр мөн Нэгдсэн хүлээн авах цонхонд хандаж дахин бүртгүүлэх шаардлагатай (2-р хэсгийг үзэх).

Үүний дараа, Префектурт энэ бүртгэлээ хийлгэснээс хойш 8 хоногийн дотор OFPRA-д дахин нээлгэх өргөдөл гаргаснаар, хавтаст хэргийг дахин нээж, таны орогнолын хүсэлтийг шалгах явц саатсан тэр үе шатнаас эхлэн дахин хянах болно.

Хэрэв та 9 сарын дотор хэрэг дахин нээлгэх хүсэлт гаргасан бол дахин нутаг дэвсгэрт байх эрх хүртэж орогнол хүсэх эрхийн гэрчилгээ олгогдоно.

9 сарын хугацаа хэтэрсэн тохиолдолд, хэрэг дахин нээлгэх хүсэлтийг тань дахин хянуулах хүсэлт шиг боловсруулах болно (3.4-рт "Дахин хянуулах" хэсгийг үзнэ үү).

### 3.4. Дахин хянах.

Таны орогнолын хүсэлтийг CNDA татгалзсан бол, эсхүүл OFPRA-ийн татгалзсан шийдвэрийг танд дуулгаснаас хойш нэг сарын дотор давж заалдаагүй бол, та OFPRA-д хандан дахин хянуулах хүсэлт гаргах боломжтой бөгөөд үүнийг зөвхөн танд ямар нэгэн « шинэ элемент » байгаа тохиолдолд буюу, өөрөөр хэлбэл шинэ элемент нь:

- CNDA-ийн шийдвэр гарснаас хойш эсбол шийдвэр гарахаас өмнө боловч та сүүлд мэдсэн байх;
- Эдгээр нь эх орондоо эргэж очход таны биеэд үзүүлэх хавчлага болон ноцтой аюул заналхийлэх эрсдэлийг нотлох магадлалтай байх.


Та холбогдох нийгэмлэг болон өмгөөлөгчөөс зөвлөгөө авч болно.

Дахин хянуулах өргөдөл гаргахын тулд та орогнол хүсэгчдийг анхлан хүлээн авах бүтэц (SPADA) дээр мөн Нэгдсэн хүлээн авах цонхонд хандаж дахин бүртгүүлэх шаардлагатай (2-р хэсгийг үзэх).

Энэхүү шинээр бүртгүүлсэн өдрөөс хойш, та дахин хянуулах өргөдлөө OFPRA-д илгээх бөгөөд танд 8 хоногийн хугацаа байх болно. Хэрэв таны өргөдөл бүрдээгүй бол OFPRA-ийн зүгээс 4 хоногийн дотор гүйцээхийг шаардах болно.

Үүний дараа OFPRA таны өргөдлийг урьдчилсан байдлаар шалгаж, хүлээн авсан өдрөөс хойш 8 хоногийн дотор хүлээн авах зөвшөөрлийн тухай шийдвэр гаргана. Энэхүү шалгалтын явцад таныг ярилцлагт дуудах шаардлагагүй болно.





Энэхүү шалгалтын үр дүнд, таны хангасан нотлох баримт болон элементүүд чанарын хувьд хамгаалал хүртэх магадлалыг илт нэмэгдүүлэх боломжгүй бол, OFPRA нь таны хүсэлтийг дахин хянахыг хүлээн зөвшөөрөхгүйгээ мэдэгдэж болно.

Хэрэв OFPRA таны хүсэлтийг хүлээн зөвшөөрснөө мэдэгдсэн бол, хурдасгасан журмаар шийдвэрлээгүй тохиолдолд, нухацтай шалгаж боловсруулах болно.

OFPRA-ийн дахин хянуулах хүсэлтийг хүлээн зөвшөөрөхгүй эсбол татгалзсан шийдвэрийг CNDA-д давж заалдаж болно (3.2-ийг хэсгийг үзнэ үү).

#### **Та дахин хянуулах хүсэлт гаргах үедээ тухайн нутаг дэвсгэрт үлдэх эрх хүртэх үү ?**

Дахин хянуулах анхны хүсэлт гаргасан тохиолдолд (3.1-рт "OFPRA -гийн шийдвэр мэдэгдсэнээс хойш үлдэх эрхийн дуусгавар" -г үзнэ үү) :

- хэрэв Префектур нь хүсэлтийг зөвхөн албадан холдуулах арга хэмжээнээс зайлс хийх зорилгоор гаргасан гэж үзсэн байх, түүнчлэн OFPRA хүсэлтийг хүлээн зөвшөөрөхгүй шийдвэр гаргасан бол, OFPRA-ийн шийдвэр мэдэгдсэн цагаас хойш та нутаг дэвсгэрт байх эрх хүртэхгүй бөгөөд, албадан холдуулах арга хэмжээнд хамрагдах ба мөн таны эсрэг уг шийдвэрийг хэрэгжүүлэх болно;
- хэрэв OFPRA таны хүсэлтийг хүлээн зөвшөөрөхгүй шийдвэр гаргасан бол, гэхдээ Префектур нь хүсэлтийг зөвхөн албадан холдуулах арга хэмжээнээс зайлс хийх зорилгоор гаргаагүйд тооцсон бол, OFPRA-ийн шийдвэр мэдэгдсэн цагаас хойш та нутаг дэвсгэрт байх эрх хүртэхгүй, гэхдээ хэрэв та CNDA-д давж заалдсан бол энэхүү давж заалдах явцын хугацаанд, таны эсрэг уг шийдвэрийг хэрэгжүүлхийг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг захиргааны шүүхэд хандан гаргах боломжтой;
- хэрэв OFPRA таны дахин хянуулах хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргаад, эцэст нь татгалзсан шийдвэр гаргасан бол, OFPRA-ийн шийдвэр мэдэгдсэн цагаас хойш та нутаг дэвсгэрт байх эрх хүртэхгүй, гэхдээ хэрэв та CNDA-д давж заалдсан бол энэхүү давж заалдах явцын хугацаанд, таны эсрэг уг шийдвэрийг хэрэгжүүлхийг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг захиргааны шүүхэд хандан гаргах боломжтой;

Дахин хянуулах хүсэлт хоёр дахь удаагаа гаргасан тохиолдолд, та нутаг дэвсгэрт байх эрх хүртэхгүй болно. Таны эсрэг нэгэн албадан холдуулах арга хэмжээ авах бөгөөд OFPRA шийдвэр гаргахаас өмнө түүнийг хэрэгжүүлэх болно.





## 4. Орогнол хүсэгчийг хүлээн авах материаллаг нөхцөл, эдлэх эрхүүд

---

Орогнол хүсэгчийн хувьд та дор дурдсан хүлээн авах материаллаг нөхцөлийг хүртэх эрхтэй, эдгээр нь:

- Танд эсбол танай гэр бүлийн гишүүдэд зориулах, орогнол хүсэгчдэд зориулсан хүлээн авах төвийн орон байр (CADA) эсбол орогнол хүсэгчдийг яаралттай байрлуулах орон байр ( 4.1-р хэсгийг үзэх) ;
- орогнол хүсэгчдэд зориулсан сар бүрийн мөнгөн тэтгэмж (ADA), үүний хэмжээг өрх гэрийн бүрэлдэхүүнд тохируулан тогтооно (4.2-р хэсгийг үзэх).

Нэгдсэн хүлээн авах цонхонд орогнолын хүсэлтээ бүртгүүлэх явцад OFII нь батлан даалт олгох журмаар таныг хүлээн авах материаллаг нөхцөлүүдийг тодорхойлж санал болгох болно (2.2.2-р хэсгийг үзэх).

Түүнчлэн та орогнолынхоо өргөдлийн явцыг хянах зорилгоор, засаг захиргааны болон нийгмийн бичиг баримт бүрдүүлэхэд халамж хүртэх, мөн түүнчлэн боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэх зэрэг асуудалд хүрэх эрхийг эдлэх болно (4.3 - 4.5 хэсгийг үзэх).

### 4.1. Орогнол хүсэгчдийг байрлуулах.

#### ■ Байрлуулах газар.


Байрлуулах газрууд нь орогнол хүсэгчдэд зориулсан хүлээн авах төвүүд (CADA), мөн орогнол хүсэгчдийг яаралттай байрлуулах орон байр (HUDA) юм. Байрлуулах орон байрыг төрөөс санхүүжүүлж, зохицуулдаг. Тэдгээрийг ихэвчлэн нийгэмлэгүүд зохицуулдаг.

Францын нийт нутаг дэвсгэрт тархсан орогнол хүсэгчдэд зориулсан бараг 100 000 байр байх бөгөөд тэдгээр нь орон сууц, нийтийн байрны төв эсбол зочид буудлын өрөө гэх хэлбэрээр байдаг болно. CADA ба HUDA-ийн байранд та зарим өрөөг бусад хүмүүстэй эсбол өөр гэр бүлтэй хуваалцах хэрэгтэй тохиолдол гарна (гал тогоо, угаалгын өрөө, бие засах газар).

Орон байр хүртэхийн тулд та орогнол хүсэх эрхийн хугацаа нь хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх ёстой.

CADA ба HUDA-д байх үед, та засаг захиргааны болон хууль эрх зүйн дэмжлэг (орогнол хүсэх үйл ажиллагааны) мөн түүнчлэн эрүүл мэнд, нийгмийн дэмжлэг (нийгмийн эрх, эмчилгээнд хүрэх эрх, хүүхдийн боловсрол гэх мэт) зэрэг тус тус давуу талыг хүртэх болно. Хэрэв та зочид буудлын өрөөнд байрладаг бол эдгээр халамжийг орогнол хүсэгчдийг анхлан хүлээн авах бүтцэд (SPADA)-аас хүртэх боломжтой.





## ■ Орон байрлуу чиглүүлэх.

Орон байр болон орогнол хүсэгчдэд зориулсан тэтгэмж (ADA) зэргийг багтаасан хүлээн авах материалыг нөхцлийг (CMA) таны бүртгүүлсэн Нэгдсэн хүлээн авах цонхонд (GUDA) байрлах OFII-с санал болгох болно :

- **Хэрэв та энэхүү батлан даалтын саналыг татгалзвал** CMA-ийн тусыг дахин санал болгохгүй.
- **Хэрэв та энэхүү батлан даалтын саналыг хүлээн авбал** OFII нь таны орогнолын процедурын дагуу тус департаментийн, мужийн эсбол нийт Францын нутаг дэвсгэрт байрлуулах орон байр байгаа эсэхийг харгалзан, CADA-д эсбол яаралттай байрлуулах орон байр (HUDA)-д санал болгоно.

Таны орогнолын өргөдөлийг бүртгэсэн департамент эсбол мужаас гадуур нэгэн байр танд санал болгож болно. Хэрэв та энэ саналыг хүлээн авахаас татгалзвал та ADA хүртэх боломжгүй болох бөгөөд, дахин өөр орон байрн санал болгохгүй.

Боломжит орон байр байхгүй тохиолдолд OFII нь таныг SPADA руу чиглүүлэх бөгөөд тэд нь орон байр эрэн сурвалжлах болно.

## ■ Орон байранд зөвшөөрөгдөх ба түүнээс гарах.

**Хэрэв таныг CADA-д эсбол HUDA-д зөвшөөрсөн** бол та орогнолынхоо процедурын нийт хугацаанд оршин суух боломжтой (OFPRA болон CNDA).


Гэсэн хэдий ч та OFPRA-ийн татгалзсан шийдвэрийг хүлээн авсны дараа тодорхой хугацаанд л тэнд үлдэх боломжтой (4.2-рт "Таны хүлээн авах материаллаг нөхцөл хэзээ дуусгавар болох вэ?" хэсгийг үзнэ үү).

**Хэрэв та орогногч эсбол субсидиар хамгаалал хүртэгч бол** (OFPRA эсбол CNDA-ийн эцсийн нааштай шийдвэр), та CADA эсбол HUDA-гийн байрыг гурван сарын дотор орхин гарах үүрэгтэй ба үүнийг нэг удаа сунгах болно. Хэрэв та энэ хугацаанаас цааш уг байранд үлдвэл шүүхээс явуулах нүүлгэн холдуулах ажиллагаанд өртөх болно.

**Хэрэв таны орогнолын хүсэлтийг татгалзсан бол** (OFPRA эсбол CNDA-ийн эцсийн татгалзсан шийдвэр), таны тухайн нутаг дэвсгэрт байх эрхийн хугацаа дуусгавар болход CADA эсбол HUDA-ийн байрыг орхих гарах шаардлагатай болно (хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд, 3.1.3.2-д "Үлдэх эрхийн дуусгавар" хэсгийг үзэх).

**Хэрэв та энэ хугацаанаас цааш орон байранд үлдвэл** та нүүлгэн холдуулах журамд хамрагдах боломжтой. Энэ хүрээнд департаментын префектурын дарга, CADA мөн HUDA-ийн удирдлага хамтаар байрыг чөлөөлөх албадан шаардлага гардуулах болно. Хэрэв та үүнийг хэрэгжүүлээгүй бол департаментын префектурын дарга буюу орон байрны удирдлага захиргааны шүүгчээр тушаал гаргуулах болно. Шаардлагатай бол, үндэсний цагдаа эсбол жандармерийн алба таныг албадан хөөх ажлыг гүйцэтгэнэ.





## 4.2. Орогнол хүсэгчдэд зориулсан тэтгэмж (ADA).

Орогнол хүсэгчдэд зориулсан тэтгэмжийн (ADA) удирдлагыг OFII хариуцах ба, түүний төлбөрийг үйлчилгээ, төлбөрийн Агентлаг олгодог.

Энэхүү тэтгэмжийг танд орогнол хүсэгчийн хувьд OFII-аас гаргасан картын тусламжтайгаар, тухайн нутаг дэвсгэрт байх эрхтэй хугацаанд тань эсбол таны орогнолыг хариуцсан өөр улс руу шилжүүлэх хүртэл олгох болно.

### ■ Түүнийг хүртэх нөхцөлүүд.

Орогнол хүсэгчдэд зориулсан тэтгэмжийг хүртэхийн тулд та :

- 1- орогнол хүсэх эрхийн гэрчилгээний эзэмшигч байх;
- 2- 18- аас дээш настай байх ;
- 3- хэрэв та орогнол хүсэгч бол, OFII-ээс санал болгосон хүлээн авах мателлаг нөхцлийг Нэгдсэн хүлээн авах цонхоор орохдоо хүлээн зөвшөөрсөн байх.

### **Би хүлээн авах материаллаг тусламжийг орогнол хүсэх эрхийн гэрчилгээгүй хүртэж болох уу?**

Дээр дурдсанчлан, хүлээн авах материаллаг нөхцлийг хүртэхийн тулд орогнол хүсэх эрхийн хугацаа хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх ёстой.

Гэхдээ хэрэв та орогнолын өргөдлөө дахин хянуулах хүсэлт гаргасан эсбол орогнолын гүйлтаа хууль ёсны үндэслэлгүйгээр хэт оройтож гаргасан бол хүлээн авах материаллаг нөхцөл хүртэх давуу талыг танд татгалзаж болно тэр нь хичнээн та орогнол хүсэх эрхийн гэрчилгээний эзэмшигч байсан ч гэсэн (2.2.1-д « Орогнолын тань хүсэлтийг тодорхойлох » хэсэгт үзэх).


Нэмж дурдахад, зарим тодорхой нөхцөл (аюулгүй улсаас гарал үүсэлтэй, нийгмийн дэг журамд ноцтой аюул заналхийлсэн) байдлаас хамааран, хурдасгасан журамд хамрагдаж орогнолын хүсэлт нь OFPRA -аас татгалзсан шийдвэр авснаар орогнол хүсэх эрхийн гэрчилгээг нь хүчингүй болгосон эсбол сунгаагүй орогнол хүсэгчид нь, OFPRA-ийн шийдвэр гарсны дараа, цааш нь CNDA-д давж заалдах бол, шүүгч шийдвэрлэтэл (захиргааны шүүгч эсбол орогнолын шүүгч), хүлээн авах материаллаг нөхцөл хүртэх болно. Энэ тохиолдолд тэтгэмжийг зохицуулан материалын тусламжгаар өөрчилж болно гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

### ■ Өргөдөл гаргах.

Хэрэв та орогнол хүсч байгаа бол, орогнол хүсэгчдэд зориулсан тэтгэмж хүртэх эрх тань Нэгдсэн хүлээн авах цонхонд орогнолын өргөдлөө бүртгүүлсний дараа нээгдэх бөгөөд, энэ нь OFII-оос танд санал болгосон батлан даалтыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд юм.

Тэтгэмжийн төлбөрийг таны орогнол хүссэн өргөдөл бүртгэгдсэнээс хойш цаад хугацаа нь 21 хоногийн дотор OFPRA-д хүргэгдсний дараа шилжүүлнэ.





### ■ Тэтгэмжийн хэмжээ.

Орогнол хүсэгчдэд зориулсан тэтгэмжийг хүртэхийн тулд таны сарын орлого нь идэвхтэй эв санааны орлогын (RSA) хэмжээнээс доош байх ёстой.

Тэтгэмжийн хэмжээг тогтоохдоо танай өрхийн бүрэлдэхүүн, орлогын хэмжээ, орон байрны төрлөөс хамаарах тооцооны хүснэгтийн дагуу явагдана.

### ■ Банкны шилжүүлгэ.

Орогнол хүсэгчдэд зориулсан тэтгэмжийн эхний төлбөр нь орогнол хүссэн өргөдөлөө OFPRA-д оруулсны дараа гүйцэтгэгдэнэ. Хэрэв та гар утасны дугаараа OFII-д дамжуулсан бол таны картанд шилжүүлгэ хийгдсэнийг SMS-ээр мэдэгдэх болно.

Тэтгэмжийг Францын нутаг дэвсгэрт оршин суух эрх тань дуусгавар болох тэр сарын эцэс хүртэл төлнө (3.1, 3.2-рт "үлдэх эрхийн хугацаа дуусгавар болох" хэсгийг үзнэ үү).

Тэтгэмжийг орогнолын хүсэлтэнд эцсийн шийдвэрийг мэдэгдсэн сараас хойшхи сарын эцэст олгохоо зогсооно.

### ■ Даван заалдах.

Таны оршин суух эрх, гэр бүлийн байдал, таны орлого, ажлын хөдөлмөр зэрэг асуудалтай холбоотой аливаа өөрчлөлтийн талаар та OFII-д зайлшгүй мэдэгдэх ёстой.

OFII-ийн гаргасан ADA-ийн шийдвэрийн талаар заргалдах тохиолдолд, та өөрийн биеэр OFII-д гомдол гаргах нь таны үүрэг бөгөөд, гэхдээ захиргааны шүүхийн хувьд бол тэр нь маргаан гарсан тохиолдолд шийдвэрлэх эрхтэй юм.

#### Ямар үед хүлээн авах материаллаг нөхцлийн тусламж дуусгавар болох вэ ?

Хүлээн авах материаллаг тусламжийг хүртэх нөхцөлийн дуусгавар нь та орогнол хүсэгчийн хувьд тухайн нутаг дэвсгэрт байх эрх тань дуусгавар болсон тэр сарын эцэст болно.

Тодорхой нөхцөл (аюулгүй улсаас гарал үүсэлтэй, нийгмийн дэг журамд ноцтой аюул заналхийлсэн) байдлаас хамааран, хурдасгасан журамд хамрагдаж орогнолын хүсэлт нь OFPRA - аас татгалзсан шийдвэр авснаар нутаг дэвсгэрт байх эрх нь дуусгавар болсон орогнол хүсэгчид нь, шүүхийн зүгээс албадан холдуулах ажиллагааг түдгэлзүүлэх хүсэлтийг нь татгалзах хүртэл, мөн CNDA шийдвэрлэтэл, хүлээн авах материаллаг нөхцлийг хүртэх болно. (5.1-г үзэх).


Хэрэв таныг орогногчоор хүлээн зөвшөөрсөн эсбол субсидиар хамгаалал хүртэх зөвшөөрөл олгосон бол, тус шийдвэрийг мэдэгдсэн сарын дараах сарын эцэст тэтгэмжийг зогсооно.

Нөгөө талаас, хүлээн авах материаллаг нөхцөлийг дараах тохиолдолд цуцалж болно :

- та орон байраа хууль ёсны шалтгаангүйгээр орхин гарсан;
- та эрх бүхий байгууллагуудын өмнө хүрэлцэн очих үүргээ биелүүлээгүй, мэдээллээр хангаах хүсэлтэнд хариу өгөөгүй, эсбол орогнол хүсэх журмын дагуу биеэчлэн ярилцлагуудад очоогүй;
- таныг OFII-ээс өөр нэгэн мужид өөр нэгэн байрлуу эсбол SPADA-д чиглүүлсэн боловч та тогтоосон тав хоногийн дотор хүрэлцэн очоогүй ;
- таныг OFII-ээс өөр нэгэн мужруу чиглүүлсэн боловч та OFII-ийн зөвшөөрөлгүйгээр гарсан.
- та санхүүгийн эх үүсвэрээ нуун дарагдуулсан;
  - та гэр бүлийн байдлын талаар худал мэдээллээр хангасан ;
  - та олон өөр овог нэрээр орогнолын хэд хэдэн өргөдөл гаргасан ;







- та хүчирхийлэлтэй зан араншин гаргасан буюу оршин сууж буй орон байрныхаа дотоод дүрмийг ноцтой зөрчсөн.

Та бичгээр тайлбар мэдүүлж OFII-д ирүүлсний дараа шийдвэрийг гаргана. Энэ нь санхүүгийн эх үүсвэрээ нуун дарагдуулсан, гэр бүлийн байдлын талаар хуурамч мэдээллээр хангасан, олон өөр овог нэрээр орогнолын хэд хэдэн өргөдөл гаргасан тохиолдолд зохих ёсоор төлөгдсөн дүнг буцаахад хүргэж болзошгүй.

### 4.3. Боловсролд хамрагдах.

Орогнол хүсэгчдийн хүүхдүүдийг үндэсний иргэдтэй нэгэн адил боловсролын системд хамруулдаг болно.

Боловсролын тухай хуульд заасны дагуу (L. 111-2-р зүйл) "хүүхэд бүр, гэр бүл нь боловсролд нь хувь нэмэр оруулснаар, сургуулийн боловсрол эзэмших эрхтэй." "Боловсролд хоёр хүйсийн, франц болон гадаад, 6-аас 16 насны хүүхдүүд зайлшгүй хамрагдах ёстой" гэдгийг дурдах нь зүйтэй (дээрх хуулийн 131-1-р зүйл).

Бага сургуулийн бүртгэлийг хотын захиргааны газар хийнэ. Та хүүхэдтэй холбоотой болох тухай, оршин суугаа газар, хүүхэд вакцинд цаг тухайд нь хамрагдсан эсэхийн талаар нотлох баримт бичгээр заавал хангах ёстой.

Ерөнхий боловсролын сургууль (коллеж эсбол ахлах сургууль) -ийн бүртгүүлийг оршин суудаг газартай хамгийн ойр байрлах сургууль дээр шууд хийнэ.

Танд эдгээр алхамыг хийхэд захиргаа, нийгэм хууль зүйн мөн түүнчлэн орон байрны дэмжлэгээр хангах үүрэгтэй байгууллагууд болон хүлээн авах анхдагч байгууллага (SPADA) зэрэг, OFII-ийг тохиролцоотой бүтэцүүд (2.1-р үзэх) туслах болно.

### 4.4. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах.

#### ■ Хаана эмчлүүлэх вэ ?

- **Мэргэжлийн эмч (нэгдсэн эмнэлгийн байгууллагаас гадна)**

Эрүүл мэндийн аливаа асуудлын талаар та эмчтэй "ерөнхий эмч", зөвлөлдөж болох ба тэр нь таныг үзэж шаардлагатай эмийг тань бичиж өгнө. Хэрэв танд нэмэлт шинжилгээ болон сувилгаа шаардлагатай бол, таныг "нарийн мэргэжлийн эмч" эсбол бусад туслах эмчилгээнд (сувилагч, иллэгийн физик эмчилгээ зэрэг) рүү шилжүүлнэ.

- **Эмийн сан:** эм худалдаж авах, эсбол зөвлөгөө авах бол.
- **Нэгдсэн эмнэлэг:** түргэн тусламж шаардагдах тохиолдол, эсбол урьчлан товлосон цагт тодорхой шинжилгээ ба нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх бол.

**Эдгээр эмчилгээ нь төлбөртэй боловч таны эрүүл мэндийн даатгалаар хариуцах боломжтой (дараагийн гарчигийг үзэх).**

**Эрүүл мэндийн даатгал олгохыг хүлээх зуур та дараах байгууллагаар үнэгүй эмчлүүлж болно :**





- Бүх төрлийн эмчилгээ:
  - Та нэгдсэн эмнэлэг бүрт байрладаг байнгын эрүүл мэндийн тусламж (PASS) дээр очиж болно. Таныг эмч нар хариуцан авч үзэх бөгөөд үнэ төлбөргүй эм олгоно.
  - Зарим түсгай мэргэжлийн холбоод (Дэлхийн эмч нар, COMEDE ...) зэрэг нь ерөнхий анагаахын үзлэг, шүдний эмчийн үзлэг эсбол нарийн мэргэжлийн үзлэгүүд (эмэгтэйчүүдийн, нүдний, сэтгэлзүйн эмч гэх мэт) үнэ төлбөргүй санал болгодог.
- Онцгой асуудлын хувьд:
  - Жирэмсэн эмэгтэйчүүдийн жирэмслэлтийг хянах, 6-аас доош насны хүүхдүүдийн вакцинжуулалтыг хянах зэргийг : PMI-ийн төвд (Эх нялхсыг хамгаалах төв)
  - Сүрьеэ өвчнийг мөрдөн илрүүлэх : CLAT (сүрьеэгийн эсрэг тэмцэх төв) -д.
  - ХДХВ, гепатит ба бэлгийн замаар дамжих халдваруудыг илрүүлэх талаар: үнэгүй мэдээлэл, үзлэг, оношилгооны төвд (CeGIDD)
  - Жирэмслэхээс урьдчилан хамгаалах хэрэгслийг олгох: гэр бүл төлөвлөлтийн төвд (CPEF)
  - Донтолтонд: донтолтын эсрэг эмчилгээ, дэмжлэг үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвд (CSAPA)

Энэ талаар мэдээлэл авах эсбол хайж олох шаардлагатай бол хүлээн авах анхдагч бүтэц, орон байрны төв эсбол орон нутгийн нэгдсэн эмнэлгээс асуух эсбол <http://annuaire.sante.ameli.fr> хаягаар орж үзээрэй.

Эмнэлэгийн түргэн тусламж шаардагдвал 15, 112 дугаарт залгах, эсбол утасдах боломжгүй бол хамгийн ойрын эмнэлгийн түргэн тусламжийн хэлтэст очно уу.

## ■ Эмчилгээний зардал төлөхөд авах туслалцаа хэрхэн олж авах вэ?

Франц Улсад эмчилгээ, сувилгаа төлбөртэй байдаг боловч та эрүүл мэндийн даатгал хүртэж түүгээрээ эмчилгээний зардлуудаа бүхэлд нь эсхүл хэсэгчлэн даалгах боломжтой.

Энэ нь Бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах даатгал ( protection universelle maladie – PUMa ) болон эрүүл мэндийг хамгаалах нэмэлт нэгдсэн ( Complémentaire santé solidaire – CSS ) даатгал юм.

Энэхүү даатгал нь бүх төрлийн эмчилгээ сувилгааг үнэ төлбөргүй хариуцах бөгөөд үүнд харааны нүдний шил, шүдний протез зэрэг хамрагддаг. Түүнчлэн, эрүүл мэндийн нэмэлт нэгдсэн даатгал нь урьдчилан мөнгө төлөхгүйгээр эмчилгээ хийлгэх болон тээврийн зардлыг хөнгөлөх боломжийг олгодог.

**Та эдгээр даатгалд хамрагдахыг хүсвэл оршин харъяа газрынхаа CPAM буюу Эрүүл мэндийн даатгалын санд хандах боломжтой :**

- **Насанд хүрээгүй хүүхдүүддээ орогнол хүссэн хүсэлтээ бүртгүүлэнгүүт :** Үүний тулд « Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд хамрагдах эрх » болон « Эрүүл мэндийг хамгаалах нэгдсэн нэмэлт даатгал » гэсэн маягтуудыг бөглөн хүүхдүүдийнхээ тухай бичсэн орогнол хүссэн өргөдлөө хавсаргахад хангалттай.
- **Та болон таны хань эсвэл хамтран амьдрагч Францад оршин суугаад 3 сар болсны дараа:** Дээрх маягтуудыг дахин бөглөөд орогнол хүссэн өргөдөл дээрээ нэмээд, сүүлийн 3 сарын турш Францад оршин суусан газрынхаа тодорхойлолтыг хавсаргана. (Оршин суух





хаягийн тодорхойлолт гэдэг нь: сүүлийн 3 сар таныг хүлээн авч амьдруулж буй газрын тодорхойлолт ; 3-аас дээш сарын хугацаанд оршин байгаа хаягийн тодорхойлолт ; 3 сараас дээш хугацаатай орогнол хүссэн өргөдөл ;, орогнол хүсэгчдийг урьдчилан хүлээн авдаг газраас (SPADA) өгсөн бүхий л баримт бичгүүд 3 сараас дээш байх ; гуравдагч этгээдийн байранд оршин сууж байгаа тохиолдолд тухайн хүний хэдэн сараас эхлэн таныг гэртээ байлгаж эхэлсэн огноогоо бичсэн итгэмжлэл болон сүүлийн 3 сарын хүчинтэй байр эсвэл гэрлийн төлбөр төлсөн баримт гэх мэт тухайн хаяг дээр оршин суудгийг тодорхойлсон баримтууд орно.

Хэрэв та өөрөө болон таны үр хүүхдүүд яаралттай эмчлүүлэх шаардлагатай бол таны өргөдлийг шуурхай хүлээн авч, эрүүл мэндийн нэмэлт даатгалд яаралтай хамрагдахын тулд яаралтай эмчлүүлэх шаардлагатайг баталгаажуулсан баримт бичгийг хавсаргаж болно.

Үүний тулд танд анхлан хүлээн авах бүтэц (SPADA), танай орон байрны төв (CADA, HUDA...) болон эмнэлгийн нийгмийн үйлчилгээ зэргээр туслах боломжтой.

**Та хүсэлтээ СРАМ-д гаргасан мөчөөс эхлэн эрүүл мэндийн даатгал үйлчилж эхлэх болно. Тийм болохоор хүүхдүүдийнхээ өргөдлийг (таны орогнол хүсэх өргөдөл гаргасан мөчөөс эхлэн) гаргаж хүлээлгүйгээр Франц Улсад та болон таны хань, хамтран амьдрагч тань 3 сар амьдарсан гэдгээ баталгаажуулах боломжтой болонгуутаа хүсэлтээ гаргах нь чухал юм.**

Та эмч, эмнэлэг, эмийн сангуудад үзүүлэх тодорхойлолт хүлээн авснаар эмчлүүлэх боломжтой болно. Уг тодорхойлолтыг өргөдлийн маягт дээрээ дурдсан хаягаар хүлээн авна. Та оршин сууж буй хаягаа уг маягт дээрээ дурдах хэрэгтэй.

Та орогнол хүссэн хугацааны турш уг даатгалд хамрагдсан байх бөгөөд хэрэв орогнолын эрхээ хүлээн авбал олон улсад эрүүл мэндийн хамгаалалттай болно. Эрүүл мэндийн нэгдсэн нэмэлт даатгал нь нэг жилийн хүчинтэй байх тул та үүнийг үргэлжлүүлэн ашиглахын тулд жил бүр шинэ хүсэлт гаргаж өргөдлөө өгөх хэрэгтэй., гэрчилгээн дээрх хугацаа дуусахаа 2-4 сарын өмнө өргөдлөө хөөцөлдөж өгөх нь зүйтэй.

**Даатгалд хамрагдахаа хүлээх хугацаанд та зардалгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээнд хамтрагдах боломжтой. Үүний тулд « Хаана эмчилгээнд хамрагдах вэ ? » хэсэгт дурдсан үнэгүй үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг хараарай.**

**Танд үзүүлэх яаралтай эмчилгээний төлбөрийг цаанаас нь төлөх болно. Үүнд, хүлээх боломжгүй эмнэлгийн үйлчилгээ орно. Жишээлбэл, гүн гэмтэл, хугарал, ноцтой эсвэл халдварт өвчин, насанд хүрээгүй хүүхдүүдийн эмчилгээ болон жирэмсэн эмэгтэйд үзүүлэх эмчилгээ (ялангуяа, жирэмсний үеийн ба дараах хяналтын үзлэгүүд болон төрсний дараах үзлэгүүд, төрөлт, жирэмслэлтийг таслан зогсоох гэх мэт) орно. Та эмнэлгийн үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагдахдаа орогнол хүссэн өргөдлөө үзүүлэх ёстой.**

#### АНХААРАЛДАА АВАХ :

**Би аж байдлынхаа өөрчлөлтийн талаар өөрийн СРАМ-д мэдэгдэх үүрэгтэй юу ?**





Та Франц Улсад 3 сараас дээш хугацаанд оршин сууснаас хойш орон нутгийнхаа CPAM -д насанд хүрээгүй хүүхдүүддээ болон өөртөө болон хань эсвэл хамтран амьдрагчдаа орогнол хүссэн мөчөөс эхлэн эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүсэлтээ гаргана.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдах эрхээ хүлээх хоорондоо та тодорхой эмнэлгийн байгууллагуудад эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, нэн яаралтай эмчлүүлэх шаардлагатай бол эмнэлэгт үзүүлэх эрхтэй. Тэгэхийн тулд та орогнол хүссэн өргөдлөө үзүүлэх ёстой.

**Та аливаа өөрчлөлтийн тухай CPAM-д мэдэгдэх үүрэгтэй.** Үүнд, орогнол хүсэх эрхийн гэрчилгээний шинэчлэгдсэн хуулбар тус бүр, оршин суух газрын шинэ тодорхойлолт, олон улсын хамгаалал хүртсэн тохиолдолд оршин суух картныхаа хуулбарыг илгээнэ үү.

#### 4.5. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх.

Орогнол хүсэгчийн хувьд, хэрэв OFPRA нь танаас хамааралгүй шалтгаанаар орогнолын өргөдөл гаргасан өдрөөс хойш зургаан сарын дотор таны орогнолыг шийдвэрлээгүй тохиолдолд, танд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох боломжтой.

Энэ тохиолдолд, та ирээдүйн ажил олгогчийнхоо гаргасан хөдөлмөрийн зөвшөөрлийг харуулан оршин суугаа газрынхаа DIRECCTE-ийн дэргэдэх ажиллах хүчний хэлтэст (SMOE) хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүссэн хүсэлт гаргах боломжтой болно.

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн өргөдөлд префектурын дарга / DIRECTE / SMOE нар шийдвэр гаргах бөгөөд хүсэлт гарснаас хойш 2 сарын хугацаанд шийдвэрлэнэ. Хэрэв энэ хугацаанд танд хариу ирүүлээгүй бол зөвшөөрөл олгогдсон гэж үзнэ. Үүнийг таны ирээдүйн ажил олгогчид төдийгүй мөн танд мэдэгдэж, тухайн нутаг дэвсгэрт байх эрхийн хугацаанд хэрэгжигдэнэ.

Зөвшөөрөл олгосон тохиолдолд, префектурын дарга 3-аас дээш сар ажиллах гэрээний эсбол улирлын чанартай ажлын гэрээний хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл OFII-д илгээнэ.


Тухайн орон нутгийн ажлын байрны хүндрэл, эсбол тухайн салбарын ажил эрхлэлтийн байдалтай холбоотойгоор, энэхүү хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг танд татгалзаж болно, гэхдээ энэ нь хэрэв та ажилд элсүүлхэд бэрхшээлтэй мэргэжлүүдийн жагсаалтанд орсон нэгэн ажлын байранд орох тохиолдолоос гадна юм.

Хэрэв та түр зуурын хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй ба танд хамааралгүй шалтгаанаар хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан эсбол богино хугацааны хөдөлмөрийн гэрээ нэг бол интеримын гэрээ дуусгавар болсон бол, та Pôle emploi-д ажил хайгчаар бүртгүүлэх хүсэлт гаргаж болно.

Хэрэв та хараа хяналтгүй насанд хүрээгүй этгээд бол, түүнчлэн суралгалтын хүрээнд мэргэшүүлэхийн гэрээ байгуулах зөвшөөрөлтэй эсбол богино хугацааны мэргэшүүлэхийн гэрээтэй бол, 2019 оны 3-р сарын 1-ээс хойш орогнолын өргөдөл гаргасан бол, гэрээгээ үргэлжлүүлэн сунгуулж болно.

Эцэст нь хэлэхэд, хэрэв та хөдөлмөрийн зах зээлд нэвтрэн орсон тохиолдолд, Хөдөлмөрийн тухай хуульд заасан нөхцлийн дагуу, мэргэжлийн сургалтанд хамрагдах боломжтой болно.





## 5. Орогнол татгалзах ба нутаг дэвсгэрт оршин суух эрхэд нөлөөлөх үр дагаварууд

### 5.1. OFPRA болон CNDA-ийн татгалзсан хариу.

#### ■ OFPRA-ийн шийдвэр гарснаас хойш үлдэх эрхийн дуусгавар.

##### ✓ CNDA-д давж заалдахыг түдгэлзүүлэхгүй :

3.1-р хэсэгт дурдсаны дагуу OFPRA-аас дараах шийдвэрийн аль нэг гарсан тохиолдолд нутаг дэвсгэрт байх таны эрх дуусгавар болно:

1. та өөр орны орогногчийн эсбол хамгааллын хүчин төгөлдөр статус хүртсэн бөгөөд тэр Улс нь ЕХ-ны гишүүн бус улс бөгөөд таныг тус оронд шилжүүлэх боломжтойн улмаас өргөдлийг хүлээн зөвшөөрөөгүй. (3.3-г үзэх);
2. хаах шийдвэр (3.3-г үзэх);
3. албадан гаргах арга хэмжээнд хамрагдах явцад дахин хянуулах анхны хүсэлт гаргасан ба хүлээн зөвшөөрөхгүй шийдвэр авсан.

Эдгээр тохиолдолд орогнол хүсэх эрхийн гэрчилгээг хураан авах эсбол шинэчлэхгүй бөгөөд Францын нутаг дэвсгэрээс орхин гарах үүргийг таны эсрэг ноогдуулах боломжтой юм. CNDA-д давж заалдахыг түдгэлзүүлэхгүй бөгөөд албадан холдуулах арга хэмжээг ямар ч үед гүйцэтгэлд орох боломжтой.

Хэрэв та OFPRA-аас орогнол хүссэн өргөдөлөө татан буулгах талаар мэдээлсэн бол та мөн нутаг дэвсгэрт байх эрхээ алдах ба CNDA-д давж заалдахыг тань түдгэлзүүлэхгүй болно.

##### ✓ CNDA-д давж заалдахыг автоматаар түдгэлзүүлэхгүй :

Нутаг дэвсгэрт байх таны эрх түүнчлэн OFPRA-аас дараах шийдвэрийн аль нэг гарсан тохиолдолд дуусгавар болно:

1. албадан гаргах арга хэмжээнд хамрагдаагүй явцад дахин хянуулах анхны хүсэлт гаргасан ба хүлээн зөвшөөрөхгүй шийдвэр авсан ;
2. дахин хянуулах хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн ба татгалзсан шийдвэр авсан;
3. аюулгүй улсын гарал үүсэлтэйгээс үүдэн хурдасгасан журамд хамрагдаж OFPRA-аас татгалзсан шийдвэр авсан ;
4. та нутаг дэвсгэрт байснаар нийтийн хэв журамд ноцтой аюул занал үзүүлж буйгаас үүдэн хурдасгасан журамд хамрагдаж OFPRA-аас татгалзсан шийдвэр авсан;
5. та захиргааны эсхүүл шүүхийн албадан холдуулах эсбол нутаг дэвсгэрийн хорио заасан захирамжинд хамрагдсан бөгөөд гэрийн хорио эсбол захиргааны саатуулганд орсон үед OFPRA-аас хүлээн зөвшөөрөхгүй эсбол татгалзсан шийдвэр авсан (2.2.1-рт «Та захиргааны эсхүүл шүүхийн албадан холдуулах эсбол нутаг дэвсгэрийн хорио заасан захирамжинд хамрагдсан үү? » хэсгийг үзэх).

1 ба 4-т заасан тохиолдолд орогнол хүсэх эрхийн гэрчилгээг хураан авах эсбол сунгахгүй бөгөөд Францын нутаг дэвсгэрээс гарах үүргийг таны эсрэг ноогдуулах боломжтой.

Та OQTF-т хамрагдсан тохиолдолд орогнолын тань хүсэлтийг түргэн хугацаанд боловсруулж, үр дүнтэй хянах зорилгоор таныг гэрийн хорионд оруулж болох бөгөөд хэрэв таны өргөдлийн тодорхой элементүүдийг тодруулах шаардлагатай эсбол үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам хамгаалах шаардлага бий бол таныг саатуулах төвд байрлуулах боломжтой .





Хэрэв давж заалдах хүсэлтийг автоматаар түдгэлзүүлэхгүй бол та захиргааны шүүхээс OQTF-ыг давж заалдах хүсэлт гаргаж болох ба энэ дагуу, та OFPRA-ийн шийдвэрийн эсрэг CNDA-д давж заалдах тэр хугацаандаа албадан холдуулах арга хэмжээг түдгэлзүүлэхийг хүсч болох бөгөөд хэрвээ CNDA-ийг хүлээн авсан бол түүнийг шийдэх хугацаа хүртэл байх юм.

